

Ч.Доржсүрэн, Ч.Дугаржав, Ц.Чулуунбаатар

ОЙН НЭР ТОМЬЁНЫ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

Улаанбаатар 2017



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Ч.Доржсүрэн, Ч.Дугаржав, Ц.Чулуунбаатар

ОЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

2 дахь хэвлэл

FOREST TERMS AND DEFINITIONS
Second edition

Улаанбаатар 2017

DDC
577

Ерөнхий редактор М.Тунгалаг
Редактор Ч.Доржсүрэн, Ч. Дугаржав, Н.Мөнхцэцэг
Техник редактор М.Ундраа

Responsible editor M.Tungalag
Editor Ch.Dorjsuren, Ch. Dugarjav, N.Munkhtsetseg
Sub-editor M.Undraa

Хэвлэсэн тоо: 500 ш
Хэвлэлийн хуудас:
ISBN

..... ХЭВЛЭЛИЙН ГАЗАР
Publishing house of

UN-REDD
PROGRAMME



Food and Agriculture
Organization of the
United Nations



UNEP
Environment
Development
Partnership

+976-77117750
www.reddplus.mn



Засгийн газрын II байр, 304 тоот, Нэгдсэн үндэсний гудамж 5/2,
Чингэлтэй дүүрэг Улаанбаатар 15160, Монгол улс

Номын ишлэлийг дараах байдлаар хийнэ.

Доржсүрэн Ч., Дугаржав Ч., Чулуунбаатар Ц. Ойн нэр томъёоны товч тайлбар толь.2 дахь хэвлэл. Улаанбаатар: хэвлэлийн газар, 2017. ... х.

Suggested citation:

Dorjsuren Ch., Dugarjav Ch., Chuluunbaatar Ts. 2017. Forest terms and Definitions. 2nd edition.Press, Ulaanbaatar, Mongolia. ...р.

Номын талаар санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж. Улаанбаатар 15160, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр.

E-mail: chdorj_07@yahoo.com, chdugaa@yahoo.com, chuluunbaatar_ts@yahoo.com

Өмнөх үг

Ойн мод нь хүн төрөлхтний нийгэм, эдийн засаг, байгаль орчин, соёл ахуйд үлэмж ашиг тус үзүүлдэг байгалийн нөхөн сэргээгддэг үнэт баялаг юм.

1992 онд Бразил улсын Рио Дэ Жанейро хотод зохион байгуулсан НҮБ-ын Байгаль орчин ба хөгжлийн бага хурлаас хойш байгаль орчин болон нийгэмд ойн нөөцийн гүйцэтгэдэг олон талын үүрэг ач холбогдлыг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч, үнэлэх болсон билээ.

Парис хотноо 2015 онд болсон НҮБ-ийн Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Талуудын 21-р бага хуралд 195 улс орон оролцож, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжих түүхэн гэрээ байгуулсан билээ. Манай улс “Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол улсын оруулах хувь нэмэр”-ийн хүрээнд 2030 он гэхэд өөрийн орны хүлэмжийн хийн нийт ялгарлыг 14 хувиар бууруулах үүрэг хүлээсэн.

Улсын Их Хурал 2015 онд “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” батлан гаргаж, БОАЖЯ-наас Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацаа (2017-2021)-ны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Монгол улсад “Ногоон хэрэм хөтөлбөр”, “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал-тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх”, “Монгол орны ойн хөгжил болон орон нутгийн ойн сангийн генийн сангийн хөгжил”, “Ойн тогтвортой менежмент хэрэгжүүлж, нутгийн иргэдийн амжиргааг сайжруулах”, “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан

зохицох нь“ зэрэг олон улсын олон хөтөлбөр хэрэгжиж байна. Монгол улс 2011 онд UN-REDD хөтөлбөрийн түнш орон болж, “Монгол орны REDD +д бэлтгэх төлөвлөгөөг”-г Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас баталсан билээ. Уг төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан Монгол орны REDD үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шийдвэрийг UN-REDD хөтөлбөрийн бодлогын хорооноос гаргаж, уг хөтөлбөрийг 2015 оны 9 сараас эхлэн хэрэгжүүлж байна. UN-REDD хөтөлбөр нь ойн доройтол болон хомсдлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн НҮБ-ийн хамтарсан санаачилга юм.

Эдүгээ төр засгаас ойн талаар гаргасан бодлогын баримт бичиг, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, бүх шатны сургалт зохион байгуулах, олон улсын болон бүс нутгийн хэмжээнд мэдлэг, туршлага солилцох, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг сайжруулахад ойн нөөц, олон талын үүрэг, ач холбогдол, түүнтэй холбоотой хэрэглэгддэг оновчтой нэр томьёо, тодорхойлолтын талаарх нэгдсэн нэг ойлголттой болох зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байгааг харгалзан үзэж, Ойн бодлого зохицуулалтын газраас ой судлаач, академич Ч.Доржсүрэн, Ч.Дугаржав, доктор Ц.Чулуунбаатар нараар “Ойн нэр томьёоны товч тайлбар“ нэр бүхий номыг захиалан бичүүлж, 2010 онд хэвлүүлсэн болно.

Эдгээр зохиогчид Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжээс санал болгосон ой болон хүлэмжийн хийн ялгаралтай холбоотой мэргэжлийн нэр томьёоны 777 мэргэжлийн үг хэллэг, нэр томьёоны гол утгыг гаргасан “Ойн нэр томьёоны товч тайлбар толь“ номны 2 дахь хэвлэлийг та бүхэнд толилуулж байна. Шинээр гарч буй энэхүү номонд өмнө нь хэвлэгдсэн “Ойн нэр томьёоны товч тайлбар“ номонд орсон мэргэжлийн нэр томьёоны үг хэллэг, тодорхойлолтыг хэвээр хадгалж оруулсан бөгөөд ойн хомсдол, доройтол, ойн хүлэмжийн хийн ялгарал,

Ойн нэр томъёоны товч тайлбар толь

шингээлттэй холбоотой нэр томъёог монгол болон англи хэлний товч тайлбартайгаар нэмж оруулав.

Монгол орны Ой модны салбарт ажиллаж буй мэргэжилтэн, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, ажиллагсад, оюутан сурагчид, эрдэм шинжилгээний ажилтан нарт зориулж энэхүү номыг хэвлэн гаргаж байна.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газрын дарга,
Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөрийн захирал
М.Тунгалаг

“Ойн нэр томъёоны товч тайлбар толь”-ийг ашиглах тухай

Аливаа толь бичгийг соёл иргэншлийн дагуул гэж нэрлэдэг. Орчин үеийн ой судлалын шинжлэх ухааны хөгжил, даяаршилын өнөө үед ойн нэр томъёоны тайлбар толь чухал ач холбогдолтой болж байна. Дэлхийн олон улс оронтой гадаад харилцаа өргөжиж буй энэ үед манай орны иргэд гадаад хэл, ялангуяа англи хэл сурахыг их сонирхох болов.

Энэ нөхцөл байдлыг харгалзан зохиогчид бид “Ойн нэр томъёоны товч тайлбар толь” номыг монгол, англи хэл дээр гаргалаа.

Энэхүү нэр томъёоны товч тайлбар тольд 777 мэргэжлийн үг хэллэг, нэр томъёоны тодорхойлолтыг оруулав. Уг тайлбар толийг бүтээхдээ мэргэжлийн товч тайлбар толь зохиодог арга, зарчмыг баримталсан болно.

Ой ба хүлэмжийн хийн ялгарлын нэр томъёог мэргэжлийн ойлголт, нэр томъёо, үг хэллэг, тодорхойлолтыг шинжлэх ухааны суурь бүтээл, ойн нэвтэрхий толь бичиг, сурах бичигт орсон байдлаар, ойн хууль, эрхзүйн баримт бичигт байгаагаар, мөн түгээмэл зарим ойлголт, тайлбарыг олон улсын нэр томъёо, тайлбар тольд орсоноор тус тус оруулав.

“Ой мод” гэсэн үгийг англи хэлний “Forest” гэсэн үгийн өргөн утгатай дүйцүүлэн авсан ба англи хэлний “Stand” хэмээх тодорхой газар ургаж байгаа модны цогц нийлбэрийг илэрхийлсэн нэр томъёог “Модод” гэж орчуулсан. Гэхдээ тодорхой газар ургаж байгаа “Ой мод”, “Ойн ургамал бүлгэмдэл”, “Модод”-ыг ярианы хэлэнд “ой” гэж нэрлэх нь олонтой тохиолддог. Түүнчлэн англи хэлний “Tree species” гэсэн үгийг “Модлог үүлдэр” гэж орчуулсан ба ярианы хэлэнд энэ үгийг “мод” гэж хэлэх нь элбэг. Иймээс зарим тохиолдолд “Модод (ой)”, “Моддын (ойн) бүрэлдэхүүн”, “Шилмүүст

үүлдэр (мод)”, Зонхилох модлог үүлдэр (мод)” гэж бичсэн нь “Моддын бүрэлдэхүүн”, “Ойн бүрэлдэхүүн”, “Шилмүүст үүлдэр”, “Шилмүүст мод”, “Зонхилох модлог үүлдэр”, “Зонхилох мод” гэж ярьж, бичдэгийг зааж байгаа хэрэг юм.

Ижил утгатай хэрэглэгддэг нэр томъёог тэгш өнцөгт хаалтан дотор бичсэн. Жишээлбэл: ойн таксац-forest mensuration [cruising, forest estimation] г.м. Монгол улсын Ойн тухай хууль болон бусад холбогдох журмаас авсан тодорхойлолтыг одоор тэмдэглэв. Жишээлбэл: эзэмшлийн ой* г.м.

Нэг нэр томъёонд хоёр янзын тодорхойлолт авсан тохиолдолд ашигласан хэвлэлийн жагсаалтанд байгаа ишлэл авсан номын дугаарыг тодорхойлолтуудын ард тавьсан болно. Жишээлбэл: ойн хэв шинж - ойн моддын төрлийн бүрэлдэхүүн, доод ташинга, хөрсөн бүрхүүлийн ургамалжилт, амьтны аймаг, ой-ургамалжилтын нөхцлийн тодорхой хэвшинжээр тодорхойлогддог ойн аж ахуйн ангилааны төрөл⁷ г.м.

Зарим тохиолдолд тайлбар: гэдэг тэмдэг хийж ойролцоо утгатай тодорхойлолтыг давхар хийлээ. Түүнчлэн “Дан идэшт”, “Манах”, “Хөнөөлийн голомт” зэрэг зарим нэр томъёоны ард юунд хамааралтай болохыг хаалтан дотор зааж өгөв. Жишээлбэл: “Дан идэшт (шавж)”, “Манах (түймэр)” г.м.

Англи үгийн товчилсон үгсийг монгол үгээр орчуулан, үгсгээр товчилж бичив.

Энэ бүтээлд нүүрстөрөгч, нүүрстөрөгчийн эргэлт, нүүрстөрөгч шингээгч, уур амьсгалын өөрчлөлт, түүнийг сааруулах, дасан зохицохуй, мөн тэрчилэн хүлэмжийн хий, хүлэмжийн хийн ялгарлын бууралт, ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, REDD+ хөтөлбөртэй холбоотой олон нэр томъёо, түүний товч тайлбар, тодорхойлолтыг оруулсан нь уг бүтээлийн нэг онцлог тал болно.

Уг толь бичигт товч тодорхойлолт өгсөн монгол нэр томъёог монгол үсгийн дарааллаар толгойлон англи үгийн хамт оруулсан болно. Үүнээс гадна англи үгээр монгол нэр томъёо, тайлбарыг түргэн олоход зориулж монгол, англи үгийн хамт, англи нэр томъёог англи үсгээр толгойлон, монгол үгийн хамт, тэрчилэн хүлэмжийн хийн ялгаралтай холбоотой нэр томъёоны англи тодорхойлолтыг номын ард жагсааж оруулсан болно. Энд англи үгээр толгойлсон нэр томъёоны ард байгаа тоо нь монгол нэр томъёо, тодорхойлолтын өмнөх дугаартай тохирно.

Энэхүү ойн нэр томъёоны товч тайлбар толийг бүтээхэд мэргэжлийн холбогдолтой англи олон үг хэллэг, тодорхойлолт болон бусад холбогдох материалаар бидний ажилд туслалцаа үзүүлсэн Монгол орны UN-REDD Үндэсний хөтөлбөрийн техникийн ахлах зөвлөх Крис Дикинсон, хөтөлбөрийн менежер Б.Хишигжаргал, мэргэжилтнүүд болон бидэнд үнэтэй санал, зөвлөмжөө ирүүлсэн бусад хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ШУА, Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич
Редактор Ч.Дугаржав

Монгол хэлний цагаан толгой

Аа	Бб	Вв	Гг	Дд	Ее
Ёё	Жж	Зз	Ии	Йй	Кк
Лл	Мм	Нн	Оо	Өө	Пп
Рр	Сс	Тт	Уу	Үү	Фф
Хх	Цц	Чч	Шш	Ъъ	Ыы
Ьь	Ээ	Юю	Яя		

Англи хэлний цагаан толгой

Aa	Bb	Cc	Dd	Ee	Ff
Gg	Hh	Ii	Jj	Kk	Ll
Mm	Nn	Oo	Pp	Qq	Rr
Ss	Tt	Uu	Vv	Ww	Xx
Yy	Zz				

A

- 1 **Аажим огтлолт**
Gradual felling
Ойн өсвөр ба залуу мод ургах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мод бэлтгэх талбай дээрх болц гүйцсэн модыг насны нэг юм уу хоёр ангийн хугацаанд 2-4 давтамжтай огтолж ашиглах үндсэн ашиглалтын огтлолт.
- 2 **Авгалдай**
Larvae
Шавжийн метаморфоз хөгжлийн 2 дахь үе.
- 3 **Агро-ойн аж ахуй**
Agroforestry
Мод, сөөгийг таримал ургамалтай хослуулан тарьж, олон талт үр өгөөжийг хүртэх цогц арга хэмжээ. Өөрөөр хэлбэл, үр бүтээмжтэй, ашигтай, эрүүл, тогтвортой, олон талт газар ашиглалтын тогтолцоог бий болгохын тулд хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн технологийг хослуулахыг хэлнэ.
- 4 **Аж ахуйн бүлэг**
Forest management group
Ой модыг зориулалтаар нь хүний үйл ажиллагаа, техникийн нөхцөлөөрөө адил, эсвэл ойролцоо ойн аж ахуйг эрхлэх ба ой ашиглалтын адил төсөөтэй горимын хэсгүүдэд нэгтгэсэн ойн сангийн зохион байгуулалт-аж ахуйн нэгж.
Тайлбар: Ой зохион байгуулалтын үед бодит эдийн засгийн нөхцөл ба ойн аж ахуйг эрхлэх горимын адил байдлыг тооцсон хамгаалалтын зэргийн бүлэг, ойн бүсээр аж ахуйн бүлгийг ялгадаг.

5 **Аж ахуйн хэлбэр (ой)**
Silvicultural type

Аж ахуйн бүлгийг дотор нь аж ахуйн зорилго, мод огтлолтын эргэлтээрээ ижил, ойн ахуйн нэг ижил үндсэн арга хэмжээ авч явуулах шаардлагатай, зонхилох нэг төрлийн модтой болон модгүй болсон ойн талбайг нэгтгэж ялгасан ойн сангийн зохион байгуулалт-аж ахуйн нэгж.

6 **Аж ахуйн хэсэг (ой)**
Forest management section

Ойн аж ахуйн үндсэн арга хэмжээ, аж ахуйн зорилгоороо нэг адил байхаар нэгтгэсэн, ойн ургамалжилтаар бүрхэгдсэн ба бүрхэгдээгүй ойн газрын нутаг дэвсгэрээр тусдаа байдаг бүх талбайг илэрхийлдэг ойн аж ахуйн бүлгийн хэмжээнд ялгасан ойн сангийн зохион байгуулалт-аж ахуйн нэгж.

Тайлбар: Ойн хэв шинж, ой-ургамалжилтын нөхцөлийн хэв шинж, ойн модны гарал үүсэл, бүтээмж, зонхилох модны үүдрээр аж ахуйн хэсгийг ялгана.

7 **Аж ахуйн цэвэрлэгээний огтлолт**
Salvage cutting

Мод хоорондын өрсөлдөөнөөс бусад гадны хөнөөлт хүчин зүйлсийн нөлөөнд гэмтсэн, хатаж байгаа болон хатаж үхсэн модыг хэрэгцээний чанар нь алдагдахаас өмнө огтолж авах цэвэрлэгээний огтлолт.

8 **Ай сав**
Cathment area [basin]

Устай уулын чулуулаг, хөрсний зузаан давхарга бүхий газрын гадаргуугийн усан хагалбараар хязгаарлагдсан хэсэг.

- 9 **Айконос мэдээ**
IKONOS data
1999 онд АНУ-ын хөөргөсөн хэт өндөр орон зайн шийд бүхий Айконос дагуулын мэдээ. Орон зайн шийд 1м-4м.
- 10 **Алаг цоог түймэр**
Spotting fire
Түймрийн хөвөөний өмнө талд харилцан адилгүй зайд шаталтын голомт бий болох.
- 11 **Алдагдалгүй хувилбар**
No-regrets options
Бусад үр ашиг нь их (эрчим хүчний зарцуулалт багасгах буюу үр ашигтай) байх тохиолдолд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад зориулсан хөрөнгө оруулалт.
- 12 **Алдагдах ялгарал**
Leakage
Төсөлд хамрагдаж буй газар нутагт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг төслөөс гадуурх бүсэд шилжүүлсний улмаас үүсэх нүүрстөрөгчийн хийн ялгаралтаас үүдэлтэй нүүрстөрөгчийн үр ашгийн буурсан хэмжээ.
- 13 **Аллометр**
Allometry
Организмын хэмжээ, хэлбэрийн хоорондын харилцан хамаарлын судалгаа; ойн аж ахуйн хувьд ихэвчлэн модны диаметр, өндөр, титмийн хэмжээ, биомассын хоорондын хамаарлыг авч үздэг.
- 14 **Амлалтын хугацаа**
Commitment period

Хүлэмжийн хийг сааруулах арга хэмжээний явцад улс орнууд тогтоосон хэмжээгээр хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах шаардлагатай цаг хугацаа.

15 **Амьсгал**

Respiration

Амьтан, ургамал бие махбодио хэвийн байлгахад шаардлагатай энергийг авахын тулд амьсгалах замаар өөрт агуулагдсан шим тэжээлийг (ихэвчлэн нүүрс-усны өндөр нэгдлээ) хүчилтөрөгчтэй исэлдүүлэх үйл ажиллагаа.

16 **Аналог зураг**

Analogue map

Цаасан дээр буулгасан зураг.

17 **Аналог мэдээ**

Analogue data

Нэгэн агшинд зургийн аппаратын тусламжтайгаар фото хальсан дээр буулгасан мэдээ.

18 **Анхдагч голомт (шавж)**

Pest outbreak [first core area of pests]

Шавжны тоо толгой олширч эхлэх талбай.

19 **Анхдагч зүйл**

Pioneer species

Нүцгэн эсвэл сүйдсэн газрыг эзлэх боломжтой зүйлүүд, тэдгээр нь ихэвчлэн экологийн солигдолд хүргэнэ.

20 **Анхдагч нийт бүтээмж (АНБ)**

Gross primary productivity (GPP)

Экосистемийн бүх бүтээгчийн метаболизмын үйл явцад (амьсгал г.м.) ялгарсан нүүрстөрөгчийг оруулахгүйгээр бүтээгчийн фотосинтезийн явцад хуримтлагдсан нүүрстөрөгчийн хэмжээ.

21 **Анхдагч ой**

Primary forest

Климакс ой гэдгийг үзэх.

22 **Анхдагч цэвэр бүтээмж**

Net primary production (NPP)

Ургамлын фотосинтезээр экосистемд бүрэлдсэн биомассын хэмжээ. Энэ нь ургамлыг амьсгалах үед бага хэмжээтэй зарцуулагдана.

23 **Аргазүйн түвшин**

Tier

УАӨЗГМХ-ны Сайн туршлагын гарын авлагад зааснаар түвшин гэдэг нь аргазүйн нарийвчлалын түвшин болно. Үүнд: Түвшин 1 нь хамгийн ерөнхий суурь түвшин бөгөөд нүүрстөрөгчийн дэлхийн нөөцийн жишиг үзүүлэлтийг ашигладаг. Түвшин 2 нь завсрын түвшин, жишиг болон үндэсний хэмжээний үзүүлэлтийг ашиглана. Түвшин 3 нь мэдээ баримтын чанар, иж бүрэн байдалд илүү өндөр шаардлага тавьдаг ба нүүрстөрөгчийн нөөцийг тооцоход гагцхүү орон нутгийн өвөрмөц үзүүлэлт ашиглана.

24 **Арчилгааны огтлолт**

Thinning

Ойг бүрэлдүүлж байгаа сайн чанарын модны өсөлтийн тохиромжтой нөхцөлийг бүрдүүлж, өндөр бүтээмжтэй ой ургуулах, ойн экологийн үүрэг ач холбогдлыг дээшлүүлэх, завсрын ашиглалтын явцад нэмэлт мод огтолж, ашиглах зорилгоор ой үүсэн бүрэлдсэн үеэс эхлэн үндсэн ашиглалтын нас гүйцэх хүртэл тодорхой давтамжтай хийдэг түүвэрлэсэн огтлолтын тогтолцоо.

25 **Арчилгааны огтлолтын арга**
Thinning method

Модны өсөлт, хэмжээ, чанарын үзүүлэлт, ойн талбай болон титэмд модны эзлэх байрлал зэргийг харгалзан огтлох ба үлдээх модыг сонгох арга. Тохируулах ба завсрын огтлолтын үед өндөр, давжаа мод, эдгээр модыг хослуулан сийрэгжүүлэх аргыг хэрэглэнэ.

26 **Арчилгааны огтлолтын давтагдах хугацаа**
Thinning interval [thinning cycle]

Арчилгааны дараагийн огтлолтыг давтан хийх хугацаа. Огтлолтын давтагдах хугацаа нь гэрэлжүүлэх ба тохируулах огтлолтонд 4-8 жил, сийрэгжүүлэх огтлолтонд 5-10 жил, завсрын огтлолтонд 10-15 жил.

27 **Арчилгааны огтлолтын хэлбэр**
Type of thinning

Ойн насны тодорхой үе шатанд хийдэг арчилгааны огтлолтын ангиллын нэгж. Арчилгааны огтлолтыг гэрэлжүүлэх, тохируулах, сийрүүлэх, завсрын огтлолт гэсэн хэлбэрүүдэд хуваана.

28 **Арчилгааны огтлолтын эрчим**
Thinning intensity

Нэг удаагийн огтлолтоор сийрүүлж авах модны тоо, нөөцийн хувь. Огтлолтын эрчмийг ойн нөөц, моддын хөндлөн огтлолын талбайн нийлбэр, титэм нийлэлтийн бууралт зэрэг үзүүлэлтээр тогтооно.

29 **Астерийн мэдээ**

Aster data

1999 онд АНУ хөөргөсөн анхны өндөр болон дунд зэргийн орон зайн шийд бүхий Астер дагуулын мэдээ. Орон зайн шийд 15м.

30 **Атрибут мэдээ**

Attribute data

Аливаа биет, юмс үзэгдлийн талаарх тайлбар мэдээ.

31 **Аукцион (ойн)**

Auction (of forest)

Тодорхой журмын дагуу хуулийн этгээд ба хувь хүн, ой мод, таваар ба бусад эд зүйлс, хөрөнгийг зарах нийтийн худалдаа.

32 **Ашиглалтын ойн бүс**

Utilization forest zone [exploitation forest zone]

Ойн экологийн ач холбогдлыг хадгалж, үндсэн ашиглалтын огтлолт хийх зориулалттай ой. Ашиглалтын ойн бүсэд хамгаалалтын бүсээс бусад ой хамаарна.

33 **Ашиглах нөөц***

Exploitation growing stock

Болц гүйцсэн ба хөгшин ойгоос үндсэн ашиглалтаар огтолж авах бололцоотой модны нөөц. Монгол улсын Ойн тухай хуулинд ашиглах нөөцийг “ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгээр тодорхой хугацаанд авч ашиглаж болох модны дээд хэмжээ” гэж заажээ.

34 **Ашигт ургамал**
Useful plants

Хүн төрөлхтөний амьдрал ахуйн өргөн хэрэглээний үйлдвэрлэл, эм, хүнс, гоёл чимэглэл, техникийн онцгой шинж чанар агуулсан ургамал.

35 **Ашигт шавж**
Beneficial insects

Төрөл бүрийн хөнөөлт шавжаар хооллогч ба тэдгээрт шимэгчлэгч шавж.

Б

36 **Байгалийн буюу in situ нөхцөлд хамгаалах**
In situ conservation

Экосистем ба унаган байгалийг хамгаалах, зүйлийн амьдрах чадвартай популяцийг байгалийн нөхцөлд нь хадгалах, онцлог шинж чанартай гаршуулсан ба нутагшуулсан зүйлийг тухайн орчинд нь хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа.

37 **Байгалийн зулзган мод [гөлгөн мод]**
Volunteer [wilding]

Суулгац материалын төрөлд ашиглагддаг 3-5 настай байгалийн гаралтай модлог ургамал.

- 38 **Байгалийн ой**
Native or natural forests
Байгалийн аясаар сэргэн ургасан уугуул модноос бүрдсэн ой.
- 39 **Байгалийн сэргэн ургалтыг дэмжих/ сайжруулах (БСУД)**
Assisted/Accelerated Natural Regeneration (ANR)
Баталгаажсан нүүрстөрөгчийн стандарт (БНС)-ын хүрээнд хэрэглэдэг арга зүйн нэр томьёо. Энэ нь уугуул ойн мод байгалийн жамаар үүсэн бүрэлдэх, цаашид өсөж бойжиход дэмжлэг үзүүлэх, ойн байгалийн нөхөн ургалтын үйл явцыг сайжруулах, түүнчлэн ойд хор хөнөөл учруулж болохуйц янз бүрийн хүчин зүйлсээс сэргийлэх зорилгоор авдаг ой менежментийн арга хэмжээ юм.
- 40 **Байгаль хамгаалагч**
Ranger
Улсын байгаль хамгааллын ажилтан.
- 41 **Байнгын мод үржүүлгийн газар**
Permanent nursery
5 жилээс дээш хугацаагаар байгуулагдсан мод үржүүлгийн газар.
- 42 **Байршил тогтоох дэлхийн систем (БТДС)**
Global Positioning System (GPS)
Байршил тодорхойлох дэлхийн систем (GPS) нь хөдөлгөөнт хүлээн авагчийг байршлын мэдээллээр хангах сансрын хиймэл дагуулуудын цуглуулга юм.
- 43 **Бие гүйцсэн шавж**
Mature insects

Шавжийн метаморфоз хөгжлийн төгсгөлийн үе.

44 **Биологийн нөөц**
Biological resource

Бодитоор ашиглах буюу цаашид ашиглах боломжтой, хүн төрөлхтөнд үнэ цэнэ бүхий генетикийн нөөц, организм ба тэдгээрийн хэсгүүд, популяци буюу экосистемийн бусад биологийн бүрэлдэхүүн хэсгүүд.

45 **Биологийн олон янз байдал**
Biodiversity

Янз бүрийн орон зайн хэмжээтэй (генээс эхлээд биом хүртэл) бүх организм, экосистемийн олон янз байдал.

46 **Биологийн олон янз байдлын тухай конвенц (БОЯБХК)**
Convention on Biodiversity (CBD)

Биологийн олон янз байдлын тухай конвенц нь биологийн олон янз байдлын бүх асуудал, тухайлбал, генетикийн нөөц, зүйл, экосистемийн асуудлыг шийдвэрлэх дэлхий нийтийн гэрээ юм.

47 **Биом**
Biomes

Биосферийн болон тухайн бүс нутгийн үндсэн элемент бөгөөд энэ нь уур амьсгалын ижил нөхцөлтэй бүсэд байгаа хэдэн хэдэн экосистем (тухайлбал, ой, гол мөрөн, нуур цөөрөм, намаг зэрэг)-ээс бүрдэнэ. Биомыг ургамал болон амьтны аймгийн түгээмэл бүлгэмдлээр тодорхойлдог.

48 **Биомасс**
Biomass

Тухайн талбай дээрх амьд организмын нийт масс; үхсэн ургамлыг үхсэн биомасст оруулна.

49 **Биомасст шилжүүлэх ба өргөжүүлэх коэффициент (БШӨК).**

Biomass conversion and expansion factor (BCEF)

Ургаа модны ишний арилжааны эзлэхүүн, жилийн өсөлтийн эзлэхүүн, эсвэл шатсан, огтолж авсан мод, түлээний модны эзлэхүүнийг газар дээрх нийт биомасс, газар дээрх биомассын өсөлт, биомассын алдагдалд тус тус шилжүүлдэг үржвэрийн коэффициент.

50 **Биомассыг өргөжүүлэх коэффициент (БӨК)**

Biomass expansion factor (BEF)

Хожуул, мөчир, найлзуур, навч, шилмүүс, заримдаа арилжааны бус мод зэрэг худалдан борлуулах зориулалтгүй буюу арилжааны бус биомассын хэсгийг тооцон, ургаа модны ишний биомасс, биомассын өсөлт, шатсан, огтолж авсан мод ба түлээний модны биомассын хуурай жинг газар дээрх нийт биомасс болгон тус тус өргөжүүлдэг үржвэрийн коэффициент.

51 **Биомассын алдагдал**

Biomass removals

Мод огтлох, ой сүйдсэний (жишээ нь, ойн түймэр) улмаас гарсан ойн биомассын алдагдал.

52 **Биомассын өсөлт**

Biomass increment

Ургамлын өсөлтийн дүнд үүссэн ойн биомассын өсөлт.

53 **Бодлого, арга хэмжээ (БАХ)**

Policies and measures (PAMs)

REDD+ийн хүрээнд бодлого, арга хэмжээ (БАХ) гэдэг нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэхээр улс орнуудын үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа юм.

54 **Боломжит өртөг зардал**

Opportunity costs

REDD+ийн боломжит зардал нь ойг хамгаалах ба нэмэгдүүлэх, эсвэл ойг газар ашиглалтын хувьд илүү үнэ цэнтэй эдэлбэр газарт шилжүүлсэнээс гарч буй цэвэр орлогын ялгаа.

55 **Болц гүйцсэн модод (ой)**

Maturity stand [exploitability]

Насанд хүрсэн модод.

56 **Болц гүйцэж байгаа модод (ой)**

Maturing stand

Модны өндөр, бүдүүний өсөлтийн эрчим буурч, болцын насны өмнөх шатанд байгаа модод.

57 **Боргоцой үрийн хортон шавж**

Seed and cone insects

Модлог ургамлын боргоцой, үрээр хооллон амьдрагч шавжууд.

58 **Бургас**

Willows [osier]

Бургасны овгийн навч нь унадаг сөөг, сөөгөнцөрийн төрөл болно. Манайд 40 гаруй зүйл бургас ургадаг. Модлог бургас 10 м хүртэл өндөр ургах ба олон настай.

59 **Буурай хөгжилтэй орнууд (БХО)**

Least Developed Countries (LDCs)

Дэлхийн хамгийн ядуу улс орнууд. Буурай хөгжилтэй орнуудыг тодорхойлохдоо Эдийн засаг, нийгмийн зөвлөл (ЭЗНЗ)-ийн боловсруулсан бага орлоготой, хүний нөөц сул, эдийн засгийн эмзэг байдал зэрэг шалгуур үзүүлэлтийг одоогоор ашиглаж байна.

60 **Бууралт (хүлэмжийн хийн ялгарал)**

Abatement (emissions)

Бууруулах. Хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ эсвэл эрчмийг бууруулах гэсэн утгаар голдуу хэрэглэнэ.

61 **Бууралтын үе (шавж)**

Crisis phase

Шавжийн хэт олшролын дараа эргээд буурах үе.

62 **Бүлгээр аажим огтлох**

Group shelterwood cutting

Ойн модыг насны хоёр ангийн хугацаанд 2-4 давтамжтайгаар жижиг бүлгээр огтолж авах аажим огтлолт.

Бүлэг мод огтлох жижиг талбайн хэмжээ нь 0.005-0.03 га байна.

63 **Бүлгээр түүвэрлэх огтлолт**

Group selection cutting

Ойн сэргэн ургалтын онцлог, модны байрлалыг харгалзан болц гүйцсэн, хөгшин модыг хэсэг бүлгээр огтолж авах түүвэрлэх огтлолт.

64 **Бүс**

Zone

Тухайн бүс нутгийн байгалийн бүсийн хуваарилалт.

65 **Бэлтгэсэн модон материал**

Harvested wood products

Мод бэлтгэх явцад ойгоос гарсан бүхий л модон (холтсыг оруулаад) материал.

66 **Бэлэн байдал**

Readiness

REDD+ийн бэлэн байдал (REDD+ стратеги, ойн хүлэмжийн хийн ялгарлын хяналтын түвшин-ОХХЯХТ, ойн үндэсний мониторингийн систем-ОҮМС, сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем-СНСМС)-ийг хангахад шаардлагатай зүйлсийг бий болгох улсын хэмжээний үйл ажиллагаа.

В

67 **Вектор мэдээ**

Vector data

Орон зайн мэдээг цэг, шулуун, полигоноор дүрслэх хэлбэр.

Г

68 **Гадаргуугийн түймэр**

Surface fire

Ойн сөөг, өвслөг ургамал, хаг, хөвд зэрэг ойн доод ташингын ургамлууд шатахад гарах түймэр.

69 **Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ойн аж ахуй (ГАГАӨОАА)**

Land Use, land Use Change and Forestry (LULUCF)

Хүлэмжийн хийн үндэсний тооллогын зургаан салбарын нэг. Энэ салбарыг дотор нь газар ашиглалтын зургаан ангилалд (ой, тариалангийн газар, бэлчээрийн газар, ус намгархаг газар, хот суурингийн газар, бусад газар)-д хуваадаг.

70 **Газар доорх биомассын нүүрстөрөгч**

Carbon in below-ground biomass

Амьд үндэсний бүх биомассанд агуулагдаж буй нүүрстөрөгч. Үүнд газар доор байгаа хожуулийн хэсэг ордог боловч 2 мм-ээс бага диаметртэй үндсийг оруулдаггүй. Учир нь эдгээрийг хөрсний органик бодис буюу хөвхнөөс энгийн аргаар ялгах боломжгүй.

71 **Газар дээрх биомассын нүүрстөрөгч**
Carbon in above-ground biomass

Иш, хожуул, мөчир, холтос, үр, навч, шилмүүс зэрэг хөрсөн дээрх бүх амьд биомассанд агуулагдсан нүүрстөрөгч.

72 **Газар эзэмшил**
Land tenure

Хувь хүн эсвэл бүлэг хүний газар эзэмших, өмчлөх эрхийн дагуу газар ашиглах хууль ёсны болон ердийн харилцаа.

73 **Газарзүйн мэдээ**
Geographic information

Байгалийн биет, юмс, үзэгдлүүд болон хүний гараар бий болсон объектын гадарга дээрх байршлын тухай координатын системд оруулсан мэдээ.

74 **Газарзүйн мэдээллийн систем**
Geographical information system

Аливаа биет, юмс, үзэгдлийн шинж чанар, орон зайн өгөгдлийг уялдуулан төлөвлөлт, судалгаа, дүн шинжилгээнд ашиглах зориулалт бүхий мэдээллийн систем.

- 75 **Газарзүйн мэдээллийн системд суурилсан мэдээллийн сан**
GIS based database
- Орон зайн тусгаг болон гол шинжийн мэдээнээс бүрдсэн өгөгдөл.
- 76 **Газарзүйн холболт**
Georeferencing [Rectification]
- Газрын зургийг стандарт тусгагт (проекткод) оруулах үйлдэл.
- 77 **Газрын ажиглалт**
Ground truth
- Агаар, сансрын мэдээнд тайлал хийж гаргасан сэдэвчилсэн зургийг газар дээрх бодит байдалтай тулгаж шалгах арга.
- 78 **Газрын доорх биомасс (ГДБМ)**
Belowground biomass (BGB)
- 2 мм-ээс их диаметртэй амьд үндэсний бүх биомасс.
- 79 **Газрын дээрх биомасс**
Aboveground biomass
- Хөрсөн дээрх амьд ургамлын иш, хожуул, мөчир, холтос, үр, навчны бүх биомасс.
- 80 **Гал асаагч аппарат**
Drip torch

Ойн шатах материалыг асаах зориулалтаар хийсэн төхөөрөмж.

81 **Гал унтраах бодис**
Fire retardant

Шаталтыг зогсоох, унтраахын тулд бүтээсэн тусгай химийн бодис.

82 **Галаас хамгаалах бодис**
Fireproofing agent

Шатах материалуудын шатах үйлчлэл болон галын дөлийг барихад зориулан бүтээсэн тусгай химийн бодис.

83 **Гацуур**
Siberian spruce [*Picea obovata*]

Ой үүсгэгч, 250-300 жил насалдаг, 30 м хүртэл өндөртэй, диаметр нь 1 м хүрдэг, мөнх ногоон шилмүүст мод.

84 **Геометрийн засал**
Geometric correction

Тоон зургийн хэлбэр дүрсийн гажгийг арилгадаг арга.

85 **Гомдол барагдуулах механизм (ГБМ) Grievance redress mechanism (GRM)**

Гомдол хүлээн авах, сонсох, хариу өгөх, түүнийг аль болох боломжит цаг хугацаанд шийдвэрлэхийг эрмэлзсэн үйл ажиллагаа.

86 **Гуурст ургамал**
Vascular plants

Нэг ба олон наст цоргот, цэцэгт ургамлууд.

- 87 **Гүймэг түймэр**
Running fire
Түймрийн хөвөө нь 0,5 м/мин-аас дээш хурдтай тархдаг, ургамлын түймэр.
- 88 **Гэмтэл, согогтой мод**
Trees with defect and injury
Янз бүрийн шалтгаанаар гэмтэл авсан, согогтой мод.
- 89 **Гэрэлжүүлэх огтлолт**
First cleaning [weeding]
Ойн бүрэлдэхүүн, үндсэн үүлдрийн модны чанар, өсөлтийг сайжруулахын тулд насны I ангийн залуу ойд хийдэг арчилгааны огтлолт. Үндсэн үүлдрийн модны өсөлт хөгжилтөд сүүдэрлэн саад болж байгаа навчит модыг голчлон огтолно.
- 90 **Гэрэлсэг шилмүүст ой**
Light coniferous forest
Нарс, шинэс зэрэг гэрэлсэг шилмүүст мод зонхилсон ой мод.

Д

- 91 **Давжаа модыг сийрэгжүүлэх арчилгааны огтлолтын арга**
Low thinning
Моддын ташингын дээд, дунд хэсэгт ургаж байгаа үндсэн модны өсөлтийн тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон тоотой ургаж байгаа давжаа модыг сийрүүлдэг арчилгааны огтлолтын арга. Энэ аргыг голдуу цэвэр ойд хэрэглэнэ.

- 92 **Давирхай**
Gum [resin, pitch, rosin, tar]
Голдуу давирхай өгдөг мод, ургамлаас боловсруулж авдаг, химийн бүрэлдэхүүнээрээ байгалийн нийлмэл, хатуу бодис.
- 93 **Давтан шатах**
Reburn
Урьд нь гүймэг түймэр гарсан талбай дээр дахин гарсан түймэр.
- 94 **Давхар үр ашиг**
Co-benefits
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээнээс гарах шууд ба дам үр ашиг. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулснаас гарах нэмэлт ашиг болно.
- 95 **Давхарга**
Layer
Газарзүйн мэдээллийн системд хэрэглэгдэх ижил координатын системтэй мэдээ.
- 96 **Дагалдах модлог үүлдэр (мод)**
Secondary tree species
Экологи, эдийн засгийн ач холбогдлоороо үндсэн үүлдрийн модноос намхан мод.
- 97 **Дагалдах түймэр**
Spot fire
Үндсэн түймрийн хүрээний гадна талд галын очноос үүссэн түймэр.
- 98 **Далд үндэстэй суулгац материал**
Balled planting [containerized seedling]

Субстрат бүхий бортого эсвэл сав дотор болон бөөн хөрсөнд үндэсний систем нь байгаа суулгац материал.

99 **Дан идэшт (шавж)**

Monophagous

Зөвхөн нэг зүйл ургамлын эд эрхтэнээр хооллогсод.

100 **Дасан зохицох сан**

Adaptation Fund

Дасан зохицох сан (ДЗС) нь Киотогийн протоколд хамрагдсан, уур амьсгалын өөрчлөлтийн тааламжгүй нөлөөлөлд өртөмтгий хөгжиж буй орнуудад хэрэгжүүлэх тодорхой дасан зохицох төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр 2001 онд байгуулагдсан.

101 **Дасан зохицох чадвар (уур амьсгалын өөрчлөлтөд)**

Adaptive capacity (climate change)

Тухайн тогтолцооны (уур амьсгалын хувьсал болон хэт эрс тэс үзэгдлийг хамарсан уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой REDD+ийн асуудлын хүрээнд) болзошгүй хор уршгийг багасгах, эсвэл боломжийн давуу талыг ашиглах болон сөрөг үр дагаврыг бууруулах чадвар.

102 **Дасан зохицохуй (уур амьсгалын өөрчлөлтөд)**

Adaptation (climate change)

Уур амьсгалын өөрчлөлтийн бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, түүний үр дагаварт байгаль, нийгмийн өртөх байдлыг бууруулах ба үр ашигтай боломжуудыг ашиглахад чиглэсэн үйл ажиллагаа.

103 **Дасан зохицохуйн менежмент**

Adaptive management

Дасан зохицохуйн менежмент гэдэг нь менежментийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн, ирээдүйн тодорхой бус ямар ч нөхцөлд дасан зохицох бодлого, дүрэм журам, арга хэмжээний нэгдмэл үйл ажиллагаа юм.

104 **Дахин ялгарах**

Reversals

Өмнө нь тооцогдсон шингээлтийн дараа дахин хүлэмжийн хий ялгарах.

105 **Долгионы урт**

Wavelength

Цахилгаан соронзон долгионыг хэмжих нэгж.

106 **Дунд насны модод (ой)**

Middle aged stand

Модны өндрийн өсөлтийн эрчим бага зэрэг буурч, бүдүүний өсөлт эрчимжиж буй насны үед байгаа модод. Ойн шургааган насны дараах үеэс эхлэн болц гүйцэж байгаа нас хүртэлх моддыг дунд насны ойд хамааруулна.

107 **Дэлхийн дулаарал**

Global warming

Дэлхийн агаарын дундаж хэм аажмаар байнга нэмэгдэх үйл явц.

108 **Дэлхэц нутаг**

Areal [range]

Амьтан, ургамлын аливаа нэг зүйлийн (төрөл, овог) тархсан газрын гадаргуугийн (усан орчны хэсэг) хэсэг.

109 **Дээж талбай**

Sample point

Агаар, сансрын мэдээнд тайлал хийх болон нарийвчлалыг шалгах зорилгоор сонгосон тодорхой цэг буюу талбай.

Е

110 **Ердийн бизнесийн хувилбар**
Business-as-usual (scenario)

Ямар нэгэн арга хэмжээ авахгүй, үйл ажиллагаа ердийн хэвээр үргэлжилсэн үед байдал ямар байх вэ гэсэн хувилбар.

111 **Ерөнхий дундаж өсөлт**
Mean annual increment

Ой, модны насны нэг жилд оногдох дундаж өсөлт.

112 **ЕРС ба ENVISAT-ийн мэдээ**
ERS and ENVISAT data

1991 онд Европын сансрын агентлагийн хөөргөсөн ЕРС дагуулын мэдээ. Орон зайн шийд 25м.

Ж

113 **ЖЕРС-ийн мэдээ**
JERS data

1992 онд Япон улсын хөөргөсөн ЖЕРС дагуулын мэдээ. Орон зайн шийд 18м.

114 **Жигд нэлд нь тарьсан ой**
Full forest plantation

Ойн бүрэлдэхүүнд тарималжуулж буй үүлдрийн зонхилох оролцоог хангасан, тэдгээрийг талбайд жигд байршуулсан таримал ой.

115 **Жигд-аажим огтлолт**
Shelterwood cutting

Ойн модыг насны нэг ангийн хугацаанд 2-4 давтамжтайгаар бүх талбайгаас жигд сийрүүлж авах аажим огтлолт. Аажим огтлолтыг жигд аажим огтлох, урт хугацаанд аажим огтлох, бүлгээр аажим огтлох, хэсэг талбайгаар аажим огтлох г.м. ангилна.

116 **Жижиг навчит модлог үүлдэр (мод)**

Small-leaved tree species

Харьцангуй жижиг навчтай модлог үүлдэр. Манай оронд жижиг навчит модонд хус, улиангар, улиас г. м. мод орно.

117 **Жижиг навчит ой**

Small-leaved forest

Жижиг навчит модлог үүлдэр зонхилсон ой мод.

118 **Жилд бэлтгэх модны зөвшөөрөгдсөн хэмжээ**

Annual allowable cut

Тухайн ой бүхий газарт жил бүр бэлтгэх модны зөвшөөрөгдсөн хэмжээ.

119 **Жимс, жимсгэнэт мод сөөг**

Berry plants [apple-tree]

Голын хөндий, татмын жимс, жимсгэнэ бүхий мод, сөөг зонхилсон байгалийн ойн мод. Үр жимс-алим, жимс, жимсгэнэ, тэдгээр нь хүнс, эм, техникийн ач холбогдолтой.

120 **Жодоо**

Siberian fir [*Abies sibirica*]

Ой үүсгэгч, 500 хүртэл жил насалдаг, 30 м хүртэл өндөртэй, диаметр нь 1 м хүрдэг, мөнх ногоон шилмүүст мод.

3

121 **Завсрын ашиглалтын огтлолт**

Intermediate cutting

Үндсэн ашиглалтын огтлолтын насанд хүрээгүй ойд арчилгааны ба цэвэрлэгээний түүвэрлэх огтлолт хийх мод ашиглалт.

122 **Завсрын огтлолт**

Advance thinning [accretion cutting]

Ойн үндсэн үүлдрийн модны шигүүрлийг зохицуулж, өсөлтийг сайжруулж, техникийн болцын насыг богиносгох зорилгоор насны IV-V ангийн ойд хийдэг арчилгааны огтлолт. Үндсэн ашиглалтын огтлолт хийхээс шилмүүст ойд 10 жилийн өмнө, навчит ойд 5 жилийн өмнө завсрын огтлолтыг хийж дуусгана.

123 **Зайнаас тандан судлал**

Remote sensing

Агаар, сансрын мэдээ ашиглан байгалийн үзэгдэл, түүний параметрууд, мөн түүнчлэн байгаль дээрх аливаа биет юмсын төлөв байдлыг судлах шинжлэх ухаан.

124 **Замаг**

Algae [sea-weeds]

Голдуу усны, доод ургамлын шигшмэл бүлэг. Ихэнх замаг микрометрийг олон хуваасантай дүйцэхүйц хэмжээтэй нэг эст организм байдаг.

- 125 **Зардал-үр ашгийн дүн шинжилгээ**
Cost-benefit analysis
Тухайн үйл ажиллагаатай холбоотой гарсан мөнгөөр илэрхийлсэн эерэг болон сөрөг нөлөөг хэмжиж, харьцуулах.
- 126 **Заримдаг сөөг**
Semishrub [subshrub]
Найлзуурын дээд хэсэг нь өвслөг бөгөөд жил бүр хатаж унадаг, доод хэсэг нь модожсон, хэдэн жил хадгалагддаг сэргэн ургалтын нахиатай олон наст ургамал. Заримдаг сөөг нь голдуу 0.8 м, хаяа 1.5 м хүртэл өндөр.
- 127 **Засаглал**
Governance
Засаглал нь нийгмийн хууль, бусад хэм хэмжээ, байгууллага болон процессийн харилцан үйлчлэл юм. Түүнчлэн яаж шийдвэр гаргах, хариуцлагатай буюу шийдвэр гаргагч этгээдэд хариуцлага хүлээлгэх зэрэг үйл ажиллагаа нь засаглалд хамаарна.
- 128 **Зах зээлийн алдагдал**
Market leakage
Төсөл эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг өөрчилсөний улмаас зах зээлийн бусад оролцогчид үйл ажиллагаагаа өөрчлөх, зогсооход хүргэснээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын өсөлт.
- 129 **Зонхилох модлог үүлдэр (мод)**
Dominant tree species

Моддын дээд ташингын нөөцийн хамгийн их хувийг эзэлдэг (насны нэгдүгээр ангид хамаарагдах зулзган ойд бол хамгийн олон тоотой байгаа) модлог үүлдэр.

130 **Зориудын буюу ex-situ нөхцөлд хамгаалах**
Ex-situ conservation

Биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн амьдрах орчноос нь гадна, өөр нөхцөлд хамгаалах.

131 **Зөөлөн навчит үүлдэр (мод)**
Hard-wood small-leaved species

Их хатуу биш модлогтой навчит үүлдэр. Үүнд хус, улиангар, модлог бургас, далдуу болон бусад мод орно.

132 **Зулзган мод**
Natural regeneration of forest [natural seeding, self-seeding]

Байгалийн модны үрнээс гаралтай 2-10 настай залуу модлог ургамал.

133 **Зулзган модод (ой)**
Young growth stand [overstocked stand]

Модны эрчимтэй өсөлт эхэлж, титэм нийлэх насны үед байгаа модод. Зулзган ойд насны нэг юм уу хоёрдугаар ангийн моддыг хамааруулна.

134 **Зурвас талбайгаар аажим огтлох**
Strip-shelterwood felling

Ойн модыг насны нэг ангийн хугацаанд 2-4 давтамжтайгаар моддын дээд өндрөөс илүүгүй өргөнтэй зурвасаар огтолж авах аажим огтлолт. Моддын дээд өндрийг тухайн талбай дээрх хамгийн өндөр модны хэмжээгээр тодорхойлно.

135 **Зургийн нарийвчлалыг үнэлэх**

Accuracy assessment

Агаар, сансрын мэдээнд тайлал хийж гаргасан сэдэвчилсэн зургийн нарийвчлалыг шалгах арга.

И

136 **Идэвхтэй шатах материал**

Flash fuel [inflammable material]

Гал тархдаг ургамлан шатах материал.

137 **Ижил хэсэгт хуваах**

Stratification

Хэсэглэн хуваах нь түүвэр судалгааны стратегийн хэсэг болох ба ангийн доторх хэлбэлзэлийг багасгахын тулд ойн бүх талбайг ижил төстэй бүтэц, онцлогтой жижиг хэсгүүдэд хуваадаг.

138 **Ил тод ба тунгалаг байдал**

Transparency and transparent

Энэ нь шийдвэр гаргах, хэрэгжүүлэх ажлыг дүрэм, журмын дагуу гүйцэтгэх ба мэдээллийг чөлөөтэй, шууд олж авах боломжтой байна гэсэн үг.

139 **Ил үндэстэй суулгац материал**

Bare-rooted planting [ball-rooted seedling]

Хөрс ба бүрхүүл субстратаас салгаж авсан ил үндэстэй суулгац материал.

- 140 **Иш ба холтосны хортон шавж**
Stem and bark insects
Холтос, модлог эдээр хооллогч шавж.

К

- 141 **Киотогийн протокол**
Kyoto Protocol
НҮБҮАӨСК-ийн дагалдах гэрээг 1997 оны 12 дугаар сард Японы Киотод НҮБҮАӨСК-ийн 3 дугаар ТБХ дээр гарын үсэг зурж баталсан. Үүгээр хавсралт-Б-д орсон улсуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үүргийг тодорхойлж, Киото хэмээн нэрлэгдсэн гурван механизмыг (“уян хатан механизм”) тодорхойлсон байдаг, үүнд: хамтын хэрэгжүүлэлт-JI, ЦХМ болон хүлэмжийн хийн худалдаа. 2005 оноос тэр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.
- 142 **Климакс ой**
Climax forest
Хөрс, уур амьсгалын тодорхой нөхцөлд зохицон, бүтэц, зүйлийн бүрдлийн хувьд хөгжлийнхөө дээд хэмжээнд хүрсэн, сүйдэж доройтоогүй, тогтвортой ойг хэлнэ.
- 143 **Консерватив зарчим**
Principle of conservativeness
Уур амьсгалын үр өгөөжийг хэтрүүлэн тооцох эрсдлийг бууруулахын тулд ялгарлын хэмжээг зориудаар багаар тооцох.
- 144 **Куикбөрдийн мэдээ**
QuickBird data

2001 онд АНУ-ын хөөргөсөн хэт өндөр орон зайн шийд бүхий Куикбөрд дагуулын мэдээ. Орон зайн шийд 0,7м-2,44м.

Л

145 **Ландсатын мэдээ****Landsat data**

АНУ эх дэлхийг сансрын уудмаас тандах зорилгоор 1972 онд хөөргөсөн Ландсат дагуулын мэдээ. Орон зайн шийд 30м.

146 **Ландшафт****Landscape**

Ландшафт нь газрын гадаргын физик төрх байдал, усан сан, газрын амьд бүрхэвч, хүний буй болгосон элементүүд, гэрэл, цаг агаарын нөхцөл зэрэг өөрчлөгдөж байдаг элементүүдийг багтаасан газар нутгийн нүдэнд харагдах онцлог шинжээс бүрдэнэ.

М

147 **Магадлагаа****Validation**

Төслийн дизайн, аргазүй, тооцоолол, стратегийг хянадаг хөндлөнгийн гуравдагч байгууллагаас гүйцэтгэдэг үйл ажиллагаа.

148 **Манах (түймэр)****Being patrolled**

Шаталтын нуугдмал голомтоос түймэр дахин сэргэхээс сэрэмжилсэн хяналт ба түймрийг устган дарах үе.

149 **Марракэшгийн гэрээ хэлцэл****Marrakesh Accords**

2001 онд хэлцэлд хүрсэн 7 дугаар ТБХ-аар Киотогийн протоколын дэлгэрэнгүй заалтыг хэрэгжүүлэх дүрэм ба хэлэлцээ.

150 **Менежмент бүхий ой**
Managed forest

Албан ба албан бусаар тогтмол хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу удаан хугацааны (тав ба түүнээс дээш) турш менежмент хийдэг ой.

151 **Мод**
Tree

Титэм бүхий гол иштэй, олон наст модлог ургамал.

152 **Мод бэлтгэл**
Logging [harvesting]

Мод хөрөөдөж унагах, цагаалах, зөөж тээвэрлэх цогц үйл ажиллагаа.

153 **Мод бэлтгэлийн нөлөөг бууруулах**
Reduced impact logging

Ойн экосистем болон ойн хүрээлэн буй орчинд хохирол багатайгаар мод бэлтгэх технологи.

154 **Мод бэлтгэсэн талбайн хэв шинж**
Type of felled area

Том модыг нь огтолсон, залуу үе удмын өсвөр модны титэм нийлээгүй ойн газрын хэсэг талбайн төрөл.

155 **Мод бэлтгэх гэрээ**
Agreement of timber harvesting [full-tree system]

Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай ойн нөөц ашиглах эрх олгосон тухай албан баримт.

- 156 **Мод бэлтгэх талбай**
Cutting area
Үндсэн ашиглалт, арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийхээр тусгаарласан талбай.
- 157 **Мод бэлтгэх талбайг зурвасаар нийлүүлэх**
Coupes on alternate strips
Мод бэлтгэсэн талбайн өргөнтэй тэнцүү хэмжээний өргөн зурвас ой үлдээж, дараачийн мод бэлтгэх талбайг авах.
- 158 **Мод бэлтгэх талбайг нийлүүлэх**
Coupe's contiguity
Янз бүрийн хугацаанд огтлох мод бэлтгэлийн талбайг тухайн огтлох ойн талбайд байрлуулах дараалал.
- 159 **Мод бэлтгэх талбайг нийлүүлэх хугацаа**
Interval of coupes contiguity
Зэргэлдээх мод бэлтгэх талбайг огтлох хугацаа. Мод бэлтгэх талбайг нийлүүлэх хугацаа нь модны их үрийн жилийн давтагдах хугацаагаар тодорхойлогдоно. Энэ хугацаа нь ихэвчлэн 3-5 жил байна.
- 160 **Мод бэлтгэх талбайг өргөн зурвасаар нийлүүлэх**
Coupes on double alternate strips
Мод бэлтгэсэн талбайн өргөнийг 2-3 дахин авсан хэмжээтэй тэнцүү өргөн зурвас ой үлдээж, дараачийн мод бэлтгэх талбайг авах.
- 161 **Мод бэлтгэх талбайг тусгаарлах**
Inventory for logging

Үндсэн ашиглалт ба арчилгааны огтлол хийх ойн хилийг тогтоож, огтлох модны тооллого хийж, материал-мөнгөн үнэлгээ өгч, мод огтлох талбайг мод бэлтгэгчдэд шилжүүлж өгөх үйлдэл.

162 **Мод бэлтгэх талбайг шууд нийлүүлэх**

Progressive coupes on contiguous strips

Дараачийн мод бэлтгэх талбайг өмнө нь мод бэлтгэсэн талбайтай зэрэгцүүлж сонгон авах.

163 **Мод бэлтгэх талбайн өргөн Width of cutting area**

Мод бэлтгэх талбайн богино талын хэмжээ.

164 **Мод бэлтгэх талбайн чиглэл Cutting area orientation**

Мод бэлтгэх талбайн урт талын зүг чиг.

165 **Мод бэлтгэх эрхийн бичиг* Felling license [felling contract, wood ticket]**

Мод бэлтгэх, хоёрдогч ойн материал, шүүс авах, давирхай авах ой ашиглагчдын эрхийг батламжилсан баримт.

Энэ нь нөхөрлөл, аж ахуй нэгж, байгууллагад ойн нөөц ашиглах эрх олгосон, төлбөр төлснийг баталгаажуулсан баримт юм.

166 **Мод огтолсны дараах сэргэн ургалт Subsequent natural reproduction**

Ямар нэг шалтгаанаар ой мод устгах ба моддыг огтолсны дараах ойн сэргэн ургалт.

- 167 **Мод огтолсон талбай**
Cutover [logged area]
Ургаа модыг нь огтолж авсан газар.
- 168 **Мод огтолсон талбайг цэвэрлэх**
Slash disposal
Мод бэлтгэлийн дараа үлдсэн гишүү, мөчир, модны үзүүр, ёзоор, унасан модыг зайлуулах юм уу овоолж үлдээх ба шатаах үйл ажиллагаа.
- 169 **Мод сөөгний суулгац материалыг хадгалах**
Storage of planting stock
Мод, сөөгний суулгацын чанарыг алдагдахаас урьдчилан сэргийлж чадах нөхцөлд тэдгээрийг хадгалах.
- 170 **Мод сөөгний тарьц**
Tree seedling [nurseling]
Үрээр ургуулсан мод, сөөгний суулгац.
- 171 **Мод судлал**
Dendrology
Модлог ургамал, тэдгээрийн гадаад ба дотоод бүтэц, ангилалзүйн байдал, зүйлийн дотоод ангилал, түүхэн гарал үүсэл, физиологи, экологи, газарзүйн тархац ба аж ахуйн ач холбогдлыг судалдаг ургамал судлалын салбар шинжлэх ухаан.
- 172 **Мод (нөхөн) тарих талбайн хөрс боловсруулалт**
Soil cultivation for reforestation

Тарималжуулж буй ургамлын өсөлтөд таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд мод тарих нийт талбай ба түүний хэсэг дээрх хөрсний механик, хими ба температурын боловсруулалт.

173 **Мод (нөхөн) тарих талбайн цэвэрлэгээ**
Site clearance before reforestation

Мод тарих талбай дахь жижиг хожуул, мод бэлтгэлийн үлдэгдэл, унанги, хэрэгцээ багатай модлог ургамал, чулууг зайлуулах.

174 **Мод үржүүлгийн газар**
Nursery [orchard, seminary]

Мод, сөөгний суулгац материалыг ургуулах зориулалттай мод үржүүлгийн газар.

Тайлбар. Мод үржүүлгийн газар гэдэгт суулгац материалыг ургуулах зориулалттай албан газар ба түүний тусгай нэгжийг ойлгоно.

175 **Мод үржүүлгийн газарт нарийн мөрөөр үр тарих**
Seed sowing in narrow strips

Мод, сөөгний үрийг 5 см-ээс доош өргөн мөрөөр тарих.

176 **Мод үржүүлгийн газарт өргөн мөрөөр үр тарих**
Seed sowing in wide strips

Мод, сөөгний үрийг 5 см-ээс дээш өргөн мөрөөр тарих.

177 **Мод үржүүлгийн газарт тарьцыг хучих**
Mulching of seedbeds in forest nursery

Мод үржүүлгийн газарт хог ургамал гарч ирэх, хөрсний гадарга дээр тав үүсэх, чийг ууршихад саад тотгор болдог янз бүрийн материалаар тарьцыг хучих.

- 178 **Мод үржүүлгийн газрыг зохион байгуулах**
Device of nursery's territory
Мод үржүүлгийн газрын талбайг янз бүрийн аж ахуйн зориулалтаар хэсэглэн хуваах.
- 179 **Мод үржүүлгийн газрын далд хөрс**
Greenhouse ground
Мод үржүүлгийн газрын талбайн хүлэмж, шилэн хүлэмж, шилэн дарлага зэрэгт суулгац материалыг ургуулахад зориулсан бойжуулах, эх ургамал, үр тарих тусгаарласан хэсэг.
- 180 **Мод үржүүлгийн газрын мод, сөөгний цуглуулгын талбай**
Part of arboretum
Мод үржүүлгийн газрын талбай дахь нутгийн мод, сөөг ба тарималжуулж нутагшуулсан үнэт зүйл, хэлбэр, эрлийзийн цуглуулгыг буй болгоход зориулсан хэсэг.
- 181 **Мод үржүүлгийн газрын ногоон мөчрийн талбай**
Part of green grafting
Мод үржүүлгийн газрын талбайн ногоон мөчир суулгахад зориулсан бойжуулгын тусгаарласан хэсэг.
- 182 **Мод үржүүлгийн газрын талбайн бойжуулах хэсэг**
Trial area of forest nursery
Мод үржүүлгийн газрын талбайн мод, сөөгийн суулгацыг бойжуулан ургуулахад зориулсан хэсэг.
- 183 **Мод үржүүлгийн газрын талбайн үр тарих хэсэг**
Sowing separation of forest nursery

Мод үржүүлгийн газрын талбайн үр тарьж ургуулахад зориулсан хэсэг.

184 **Мод үржүүлгийн газрын эх ургамлын хэсэг**
Mother tree plantation

Мод үржүүлгийн газрын талбайн үр, тайрдас гарган авах зорилгоор мод, сөөгийг ургуулахад зориулсан хэсэг.

185 **Мод үхэж цөөрөх**
Dead and down tree

Ойн модны байгалийн сийрэгжилт, өвчин гэмтлээс шалтгаалж үхсэн мод.

186 **Мод цагаалах**
Skidding

Хөрөөдөж унагасан мод, тууш мод, гуалинг мод ачих талбай руу трактор, бусад хэрэгслээр чирж зөөх үйл ажиллагаа.

187 **Мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ**
Forest products certificate [wood certificate]

Мод, модон материалыг нийслэл, өөр аймаг, сум, тэдгээрийн хооронд тээвэрлэх, худалдахад ойгоос зохих журмын дагуу бэлтгэсэн мод болохыг гэрчилсэн баримт.

188 **Мод, сөөгний жишгийн суулгац материал**
Standart planting stock

Стандартчилалын норм-техникийн баримт бичгийн шаардлагад нийцэж буй мод, сөөгний суулгац материал.

- 189 **Мод, сөөгний суулгац**
Seedling
Модлог ургамлын ургал эрхтнийг үндэслүүлэх замаар ба шилжүүлэн суулгасан тарьцнаас ургуулан авсан мод, сөөгний суулгац материал.
- 190 **Мод, сөөгний суулгац материал**
Planting material [planting-stock]
Мод үржүүлгийн газар, ойжуулах талбай, ногоон байгууламжинд суулгахаар зориулсан модлог ургамал ба түүний хэсэг.
- 191 **Мод, сөөгний суулгац материалын бүртгэл, тооллого**
Inventory of planting material
Мод үржүүлгийн газарт тарих үр ба суулгацын талбай, ургуулсан тарьц, суулгацны тоо, чанарыг тодорхойлох.
- 192 **Мод, сөөгний суулгац, материалыг ургуулах технологи**
Method of growing of planting material
Мод үржүүлгийн газар тусгай чанартай суулгац материалыг ургуулах ажиллагааг хангадаг цогц агротехникийн арга, ажиллагаа.
- 193 **Мод, сөөгний суулгацыг зэрэглэх**
Sorting of planting stock
Хөрснөөс ухаж авсан мод, сөөгийг стандартчилалын журам-техникийн баримт бичгийн шаардлагад нийцүүлэн чанараар нь ангилан хуваах.
- 194 **Мод, сөөгний суулгацын нас**
Age of planting stock

Суулгац материалын төрөлд ашиглагдаж буй ургамал ба түүний хэсэг эрхтний гарч ирсэн цаг үеэс улиран өнгөрсөн жилийн тоо.

195 **Мод, сөөгний суулгацын хэлбэржүүлэлт**
Formation tree seedlings

Мод, сөөгний суулгацын газрын дээд хэсэгт тодорхой хэлбэр оруулах ажиллагаа.

196 **Мод, сөөгний тарьцыг сүүдэрлэх**
Shading of seedlings

Нарны шууд туяаны хортой нөлөөнөөс мод, сөөгний тарьцыг хамгаалах арга.

197 **Моддын (ойн) болцын нас**
Maturity age of stand

Моддын өсөлт, хөгжилтийн тодорхой үе шатыг илэрхийлж, аж ахуйн зорилгод хамгийн сайн тохирсон тоон ба чанарын шинж тэмдэг илрэх нас. Болцыг тооны болц, техникийн болц, сэргэн ургалтын болц, байгалийн болц г.м. олон хэлбэрт ангилна.

198 **Моддын (ойн) бүрэлдэхүүн**
Stand composition

Ойг бүрэлдүүлж байгаа модны нэрсийн эхний үсгийг томоор бичиж, тэдгээрийн оролцоог хувиар илэрхийлсэн үзүүлэлт. Моддын бүрэлдэхүүнийг нийлмэл модны нэр, бүрэлдэхүүний коэффициентээр илэрхийлнэ. Үүнд модны нэрийг эхний 1 ба 2 үсгээр бичнэ. Тухайлбал шинэсийг Ш, нарсыг Н, хусыг Хс, хушийг Хш гэж тэмдэглэнэ. Ойн нөөцөд модны төрөл бүрийн эзлэх хувийн жинг бүрэлдэхүүний коэффициент (К) гэнэ. Тухайн модны нөөц нь моддын нөөцийн 6-15 хувийг эзлэж байвал $K=1$, 16-25 % -д $K=2$, 86-95 %-д $K=9$, 95 %-иас дээш үед $K=10$ байх ба 2-5 % үед коэффициентийг + тэмдгээр, 2 хүртэл хувьд «нэгж» гэсэн үгээр тэмдэглэж модны нэрийн өмнө бичнэ. Жишээ нь 10Ш, 6Ш4Хс, 7Ш4Хс+Хш нэгж Н г.м.

199 **Моддын (ойн) дундаж өндөр**
Stand average height

Ойг бүрэлдүүлж байгаа бүх модны дундаж өндөр. Ойн аж ахуйд модны өндрийн арифметик дундаж олох, эсвэл модны диаметр, өндрийн графикаас ойн дундаж диаметрт тохирох өндрийг авч ойн дундаж өндрийг тодорхойлно.

200 **Моддын (ойн) насны анги**
Age class

Ойн сан, моддын насны бүтцийн онцлог шинж, моддын насны бүлэг, үе шатыг ялгахын тулд модлог үүлдрийн биологийн онцлогоос хамааруулан тогтоосон насны зааг. Насны ангийг шилмүүст модонд 20 жилээр, навчит модонд 10 жилээр авч Ром тоогоор дугаарлана. Жишээлбэл: I (шилмүүст модонд 0-20 нас, навчит модонд 0-10 нас), II (21-40, 11-20), III (41-60, 21-30) г.м.

201 **Моддын (ойн) насны бүлэг**
Age group [gradation]

Өсөлт, хөгжилтийн тодорхой насны үе шатанд байгаа моддын бүлэг.

202 **Моддын (ойн) насны үе шат**
Age stage of stand

Аж ахуйн чухал ач холбогдолтой шинж тэмдэг харьцангуй тогтвортой, тод ялгарч байгаа моддын өсөлт, хөгжилтийн үе.

203 **Моддын (ойн) нөөц**
Growing stock [stand volume]

Ой ургаж байгаа бүх модны ишний эзлэхүүн.

204 **Моддын (ойн) өтгөрөл**
Stocking level [stand density]

Ургаж байгаа талбайнхаа гадаргын орон зайг модод хэр зэрэг ашиглаж байгааг модны ишний хөндлөн огтлолын талбайн нийлбэрээр илэрхийлэн харуулсан үзүүлэлт. Өтгөрлийг үнэмлэхүй ба харьцангуй гэж ялгадаг.

Үнэмлэхүй өтгөрөл гэдэг нь нэгж талбайд ногдох модны хөндлөн огтлолын нийлбэр бөгөөд $m^2/га$ гэсэн үнэмлэхүй нэгжээр илэрхийлэгдэнэ.

Харьцангуй өтгөрөл нь тухайн ойн үнэмлэхүй өтгөрлийг 1.0 өтгөрөлтэй жишиг ойн үнэмлэхүй өтгөрөлд харьцуулж, аравны нэгжээр илэрхийлсэн үзүүлэлт.

205 **Моддын (ойн) ташинга**
Stratum [canopy layer]

Ойролцоо өндөртэй модноос бүрэлдсэн, моддын босоо бүтцийн хэсэг.

206 **Моддын (ойн) титэм нийлэлт**
Canopy closure [crown closure]

Моддын титэм тухайн ойн талбайг хэр зэрэг бүрхсэнийг хэвтээ хавтгай дээрх модны титмийн тусгаг бүрхцээр илэрхийлэн харуулсан үзүүлэлт.

Модны титмийн хамгийн их бүрхцийг 1.0 гэж үзээд титмийн бүрхцийг аравны нэгжээр илэрхийлнэ.

207 **Моддын (ойн) хэлбэр**
Form of stand

Моддын босоо бүтэц буюу ташинга үүсгэсэн байдлыг илэрхийлэх таксацын үзүүлэлт. Ойг хэлбэрээр нь энгийн ба нийлмэл ой гэж ангилна.

208 **Моддын (ойн) шигүүрэл**
Density of trees

Тухайн ойн талбайн орон зайг модод хэр зэрэг ашиглаж байгааг модны тоогоор илэрхийлсэн үзүүлэлт.

209 **Модлог**

Timber [wood]

Дамжуулах, механик ба нөөцлөгч үүргийг гүйцэтгэдэг, эдийн камбийгаар үүссэн цогц нэгдэл. Модлог ургамлын мөчир, үндэс, ишний үндсэн цулыг модлог бүрдүүлдэг.

210 **Модлог ургамал**

Woody plants

Модлог иштэй ургамал. Модлог ургамалд мод, сөөг, хагас сөөг орно.

211 **Модлог үүлдэр, модны төрөл**

Tree species

Модлог ургамлын ангилалзүйн төрөл (ярианы хэлэнд модлог үүлдрийг голдуу мод гэж хэлдэг).

212 **Модны бүрхэц**

Tree cover

“Титмийн бүрхэц”-ийг үз.

213 **Модны ишний гал**

Tree fire [stem fire, leg fire]

Тухайн талбай дээр гарсан түймэртэй холбоотой эсвэл түймрээс шалтгаалахгүйгээр модны иш шатах.

214 **Модны оройн хаталт**

Top drying [dieback]

Амьд модны орой хатах.

- 215 **Модны суулгац (үр)-ыг байршуулах зай**
Spacing of planting [sowing], treeplanting
Эгнээ шугмын дагуу тарьсан суулгацны хоорондын зай.
- 216 **Модны суулгац тарих**
Treeplanting
Таримал ой буй болгох зорилгоор нэг ба хэд хэдэн төрлийн модны суулгац материалыг тарих.
- 217 **Модны суулгац (үр)-ыг байршуулах**
Planting [sowing] point
Таримал ой буй болгох талбай дээр модны үр ба модны суулгац материалыг байршуулах байр.
- 218 **Модны үр тарих**
Direct seeding
Таримал ой буй болгох зорилгоор нэг ба хэд, хэдэн төрлийн модны үрийг тарих.
- 219 **Модны үүлдэр солигдолт**
Alternation of tree species [stand succession]
Ойн ургамалжилтын байгалийн хөгжилт эсвэл байгалийн ба хүний нөлөөгөөр мод устах, модыг огтлох, ой-ургамалжилтын нөхцөлийн өөрчлөлттэй холбоотойгоор ойн моддын бүрэлдэхүүн солигдох үзэгдэл.
- 220 **Модны холтос**
Bark (tree)

Модлог ургамлын тулгуур эрхтний хоёр дахь бүдүүн зузаан болох үед зулмаас (түүний гадна талаар) үүсдэг бүх эд. Холтос нь хоёрдогч долон ба хучаасыг багтаасан байдаг.

221 **Модны холтсыг тойроогоор зурваслаж хуулах**
Band girdling

Муу модыг хатааж үхүүлэх зорилгоор түүний холтос, золмыг нарийн тойргоор зурвасаар хуулж авах.

222 **Модны цухуйц**
Germinant [plantlet young seedling]

Үрнээс үүссэн нэг хүртэлх насны модлог ургамал.

223 **Модны эзэлхүүн**
Volume of tree

Модны ишний эзэлхүүний тоо хэмжээ, шоо метрээр илэрхийлэгдэнэ.

224 **Модод (ой)**
Stand

Тухайн ургамал бүлгэмдлийн хүрээнд өөр хоорондоо нарийн зүй тогтол, харьцаатайгаар ургаж байгаа бүх модны нийлбэр цогц (ярианы хэлэнд моддыг голдуу ой гэж хэлдэг).

225 **Модон материал**
Wooden [woody] materials

Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, бөөрөнхий мод, түлээ, зүсмэл материал, дүнз, дүнзэнцэр, цэвэр болон захтай банз, савх мод зэрэг.

- 226 **Модон түүхий эд**
Raw-wood [wood raw material]
Өндөр температурын үеийн даралт, холбогч бодисуудаар нэвчүүлэх, цавуудан наалдуулах зэргээр модлогийг боловсруулах замаар гарган авч байгаа зохион бүтээх, тусгаарлах буюу дууриалган хийсэн материал.
- 227 **Мониторинг (уур амьсгалын өөрчлөлт)**
Monitoring (climate change)
Хүний нөлөөгөөр үүссэн хүлэмжийн хийн ялгарлыг хэмжихдээ эх үүсвэрээр нь (юм уу шингээгчээр нь), үндэсний болон төслийн хил хязгаар (хэрвээ хүлэмжийн хийн ялгарлын алдагдал төслийн түвшинд бол)-ын хүрээнд бүх холбогдох тоон өгөгдлийг цуглуулах, архивлах.
- 228 **Мөнх ногоон ургамал**
Evergreen
Жилийн турш ногоон шилмүүс, навчтай байдаг ургамал.
- 229 **Мөөг**
Fungi [mushrooms]
Хлорофиллийн мөхлөггүй организмуудын бүлэг. Фотосинтезлэгч ургамлуудаас эрс ялгаатай мөөгний энэ бүлэг организмын өвөрмөц аймаг.
- 230 **Мөчир**
Branch [limb]

Модны үндсэн эрхтний нэг, ишний тодорхой өндөрт титэм үүсгэнэ. Өмнөх жилийн найлзуур дээрх нахианаас жил, жилийн шинэ өсөлтийн найлзуур үүсэх явцын үр дүнд мөчир үүснэ.

231 **Мөчрийн согдуул**
Сорпice

Бие дааж ургах чадвартай, үндэслэсэн найлзуураас үүссэн залуу ургамал.

232 **Мэдээллийн сан**
Database

Тодорхой стандартаар илэрхийлэгдсэн өөр хоорондоо холбоо бүхий өгөгдөл.

Н

233 **Навч, шилмүүсний хортон шавж**
Defoliating insects

Модлог ургамлын навч шилмүүсээр хооллогч шавжууд.

234 **Навчаа гөвдөг мод, сөөг**
Deciduous

Жил бүр эсвэл тодорхой хугацаанд навч нь унадаг мод, сөөг.

235 **Навчит модтой шилмүүст ой**
Hard-wood and coniferous stand mixed

Шилмүүст, навчит модноос бүрэлдсэн, дээд ташингад нь шилмүүст мод зонхилсон ой.

236 **Навчит ой**
Broad-lived forest

Навчит мод зонхилсон (модны титмийн бүрхэц 75% -иас дээш) буюу цэвэр навчит ой мод.

237 **Навчит үүлдэр (мод)**

Broad-leaved tree [hard-wood species]

Ургамлын ангилал зүйн хувьд Angiospermae буюу бүрхүүлт үртний хүрээнд хамаарагдах бүх модлог үүлдэр. Эдгээрийг зарим тохиолдолд “шилмүүст бус мод” буюу “хатуу мод” гэж нэрлэдэг. Навчит модонд ихэвчлэн бариул бүхий хавтага навчтай мод, сөөг орно.

238 **Намаг (ой)**

Marshy area

Титэм нийлсэн ой мод үүсэх нөхцөлгүй хэт илүүдэл чийгтэй, модлог ургамалтай болон ургамалгүй ойн бус талбай.

239 **Нарийвчилсан буюу суурин судалгаа**

Detailed or stationary surveillance

Олон жилийн хугацаанд зохион байгуулах суурин судалгааны арга.

240 **Нарийн талбайгаар хавтгайруулсан огтлолт**

Strip-clear cutting

Бага хэмжээтэй мод бэлтгэх талбайд хийдэг хавтгайруулсан огтлолт. Мод бэлтгэх талбайн өргөн 100 метрээс илүү гарахгүй.

241 **Нарс (мод)**

Scots pine (tree) [*Pinus sylvestris*]

Ой үүсгэгч, 150-500 жил насалдаг, 30 м хүртэл өндөр ургадаг, диаметр 1.0 м хүрдэг, мөнх ногоон шилмүүст мод.

242 **Насны нэг үеийн мод**
Cohort [trees of single generation]

Сэргэн ургалтын нэг үед үүссэн, ойролцоо настай модод. Насны нэг үед хамаарагдах мод нь дундаж насны болон болц гүйцэж байгаа ойд насны 1 ангиас илүүгүй, болц гүйцсэн болон хөгшин ойд 2 ангиас илүүгүй, XI ангиас дээш настай их хөгшин ойд 3 ангиас илүүгүй насны зөрөөтэй модноос бүрэлдэнэ.

243 **Нахиа, найлзуурын хортон шавж**
Bud and shoot insects

Модлог ургамлын нахиа, найлзуураар хооллон амьдрагч шавжууд.

244 **Нийлмэл модод (ой)**
Stratified mixture stand

Хоёр ба түүнээс дээш ташингаас бүрэлдсэн модод.

245 **Нийтийн эзэмшил дэх газар (ой)**
Land (forest) under public ownership

Улс (үндэсний, улс, бүс нутгийн засаг захиргаа) ба төр-хувийн байгууллагууд, корпораци ба хот, нутгийн захиргаа, сум, суурин баг гэх мэт нийтийн эзэмшилд байгаа газар (ой).

246 **НОАА-ийн мэдээ**
NOAA data

АНУ дэлхий орчмыг тандах, цаг уурын зориулалттайгаар 1960 онд хөөргөсөн НОАА дагуулын мэдээ. Орон зайн шийд 1км.

247 **Ногоон бүсийн ой**
Green zone forests

Хот суурин газрын ойролцоо оршдог, тэдгээрийг хүчтэй салхи, хөдөлгөөнт элс, тоосноос хамгаалах, уур амьсгал зөөлрүүлэх, эрүүл ахуй, амралтын ач холбогдол бүхий байгалийн ой мод, парк. Тайлбар: Улсын нийслэлд эргэн тойрон 80 км хүртэл, аймгийн төвд 30 км, сум, суурин газарт 15 км хүртэл зайнд оршиж байгаа ой модыг ногоон бүсийн ойд оруулна.

248 **Ногоон мөчрийн тайрдас**
Green branch [cutting]

Ургамлын вегетацийн үе дэх моджоогүй найлзуураас бэлтгэсэн навчтай тайрдас.

249 **Ноголгоо**
Verification

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг эх үүсвэрээр нь эсвэл нүүрстөрөгчийн нөөцийн ихэссэн байдалд тодорхой хугацаанд хийдэг бие даасан хяналт, дүгнэлт.

250 **Нөөцлүүр**
Reservoirs

Хүлэмжийн хий юм уу, хүлэмжийн хий үүсгэгч урьтал бодисууд хадгалагдаж байдаг уур амьсгалын системийн бүрэлдэхүүн хэсэг.

251 **Нөхөн сэргээж сайжруулахуй (ой)**
Rehabilitation (forest)

Ойн бүтээгдэхүүн ба үүргийн чадамжийг нөхөн сэргээж сайжруулах зорилгоор доройтсон ойд явуулах менежментийн стратеги.

252 **Нутаг дэвсгэр**
Territories

Нутгийн уугуул иргэдэд онцгой хамаатай бүс нутаг ба энэ нь тухайн хүмүүсийн ашигладаг нутаг дэвсгэр болно.

253 **Нутгийн иргэдэд түшиглэсэн ойн аж ахуй**
Community forestry

Ойн нөөцийн менежментийг нутгийн иргэдийн тусын тулд тэдэнтэй хамтарч хэрэгжүүлдэг ойн менежментийн тогтолцоо.

254 **Нутгийн тойм зураг**
Area seen map

Тухайн нутгийн байгаль ба объектийн онцлог хэсгийг тоймлон тэмдэглэсэн, ажиглах пункт орчмын эргэн тойрныг харуулсан газрын зураг.

255 **Нутгийн уугуул иргэд**
Indigenous people

Нутгийн уугуул иргэдийн талаарх олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт байдаггүй. Бүс нутагт оршин сууж байгаа тус нутгийн бүлэг хүн болон угсаатны бүлгийг ерөнхийд нь ингэж нэрлэдэг.

- 256 **НҮБУАӨСК-ийн Хавсралт 1, Хавсралт Б-ын орнууд /талууд**
Annex-I, Annex-B Countries/Parties
Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн бүх хөгжилтэй болон эдийн засгийн шилжилтийн улсуудыг хамарсан НҮБУАӨСК-ийн Хавсралт I-д (1998 онд шинэчлэгдсэн) хамрагдах улс орнуудын бүлэг.
- 257 **НҮБУАӨСК-ийн Хавсралт II-ын орнууд**
Annex II countries
Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн бүх хөгжилтэй орнуудыг хамарсан НҮБУАӨСК-ийн Хавсралт II-т хамрагдах бүлэг улс орон.
- 258 **Нүүдлийн голомт (шавж)**
Migration hotspot
Идэш тэжээлийн шаардлагаар шилжин нүүдэллэх талбай.
- 259 **Нүүрстөрөгч шингээгч**
Carbon sink
Нүүрсхүчлийн хийн шингээлтийн дүнд нүүрстөрөгчийн хуримтлал бий болж байдаг газар, орчин.
- 260 **Нүүрстөрөгчийн ашиг**
Carbon benefits

Тогтворгүй байдал болон гаднах алдагдлыг тооцон зохих хасалт хийсний дараа ердийн явагддаг үйл ажиллагааны хувилбараас (BaU) дээш гарсан нүүрстөрөгчийн хуримтлал эсвэл ялгаруулахаас сэргийлсэн нүүрстөрөгчийн хэмжээ.

261 **Нүүрстөрөгчийн дүйцүүлэлт**

Carbon offset

Ялгарлыг бууруулахаар төлөвлөсөн хэмжээг нөхөж дүйцүүлэхийн тулд нүүрстөрөгчийн кредитийг худалдан авах ба нүүрсхүчлийн хийг шингээх арга хэмжээ авах.

262 **Нүүрстөрөгчийн кредит**

Carbon credit

Нэг тонн нүүрсхүчлийн хий эсвэл бусад төрлийн хүлэмжийн хийн хэмжээг нэг тонн нүүрстөрөгчийн давхар эслийн эквивалент (CO₂ тонн.экв)-тай тэнцэх утгаар илэрхийлсэн хүлэмжийн хий гаргах эрхийг төлөөлөх зөвшөөрөл ба худалдаалах сертификатын ерөнхий нэршил.

263 **Нүүрстөрөгчийн нөөц**

Carbon stock

Нүүрстөрөгчийн нөөц сангийн нэгж талбайд тонноор хэмжигддэг нүүрстөрөгчийн хэмжээ. Жишээ нь амьд биомасс (газар доорх болон дээрх биомасс), үхсэн органик бодис (үхсэн мод, унаш, хөвх), хөрс (хөрсний органик хэсэг) зэрэг нь нүүрстөрөгчийн нөөцлүүр.

264 **Нүүрстөрөгчийн нөөц сан**

Carbon pool

Нүүрстөрөгчийг ялгаруулах эсвэл хуримтлуулах чадвартай тогтолцоо. Ойд нүүрстөрөгчийн таван үндсэн сан байдаг. Үүнд: газрын дээрх биомасс, газрын доорх биомасс, үхсэн ба унанги мод, хөвхөн давхарга, хөрсний органик бодис юм.

265 **Нүүрстөрөгчийн нөөцийг нэмэгдүүлэх Carbon stock enhancement**

Доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, шинээр ой үржүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа.

266 **Нүүрстөрөгчийн сайн дурын зах зээл (НСДЗЗ) Voluntary carbon market (VCM)**

Олон улсын хэлэлцээр ба нүүрстөрөгчийн албан ёсны хүрээнээс гадуурх байгууллага, (жишээ нь, эрчим хүч болон агаарын тээврийн компаниуд) болон хувь хүний зах зээл.

267 **Нүүрстөрөгчийн тооцоо Carbon accounting**

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын эх үүсвэр, шингээгчтэй холбоотой нүүрстөрөгчийн нөөц сангийн өөрчлөлтийг ажиглаж тооцох.

268 **Нүүрстөрөгчийн худалдаа буюу ялгарлын арилжаа Carbon trading or emission trading**

Хүлэмжийн хий ялгаруулах зөвшөөрөл, хөнгөлөлт, кредитийн борлуулалт эсвэл худалдан авалт.

269 **Нүүрстөрөгчийн шингэлт Carbon sequestration**

Ургамал, мод болон ургамлын бусад төрөл зүйл ургах явцдаа агаар мандлаас нүүрсхүчлийн хийг шингээж хуримтлуулахыг хэлнэ.

270 **Нүүрстөрөгчийн эргэлт**
Carbon cycle

Агаар мандал, далай тэнгис, эх газрын биосфер, литосфер дэх нүүрстөрөгчийн (нүүрсхүчлийн хий, биомассын нүүрстөрөгч г.м янз бүрийн хэлбэртэй) урсгал.

271 **Нүүрстөрөгчийн эрх**
Carbon rights

Нүүрстөрөгчийн нөөц сангуудаас бий болох үр ашигт үндэслэсэн баталгаажсан эрх. Ойн хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, эсвэл ойн нүүрстөрөгчийг шингээх замаар ашиг хүртэх эрх зүйн үндэс.

272 **Нүүрстөрөгчийн эх үүсвэр**
Carbon source

Нүүрстөрөгчийн урсгал нь цэвэр ялгарал бий болгож байдаг нүүрстөрөгч нөөцлөгч.

273 **Нүүрстөрөгчийн ялгаралгүй**
Carbon neutral

Нүүрстөрөгчийн ялгарлын ул мөр байхгүй байх.

274 **Нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээ**
Carbon footprint

Хувь хүн, хүн ам, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа зэргээс үүдсэн ялгарал бөгөөд ихэвчлэн нүүрсхүчлийн хийн эквивалент (CO₂e) тонноор хэмжигддэг.

- 275 **Нүүрсхүчлийн хийн эквивалент (CO₂e)**
Carbon dioxide equivalent (CO₂e)
Долоон төрлийн хүлэмжийн хий тус бүрийн дэлхийг дулааруулах чадамжийг илэрхийлэхэд хэрэглэдэг хэмжилтийн түгээмэл нэгж. Үүнийг төрөл бүрийн хүлэмжийн хийн ялгарлын (эсвэл сэргийлсэн ялгарлын) нөлөөллийг тооцоход хэрэглэнэ.
- 276 **Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБҮАӨСК)**
United Nations Framework Convention on Climate Change (UNFCCC)
Олон улсын уур амьсгалын хэлэлцээрийн удирдан чиглүүлэх ерөнхий үндсийг тавих зорилгоор 1992 оны Риогийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаар баталсан олон улсын гэрээ хэлэлцээр.
- 277 **Нэмэгдэл чанар (хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах)**
Additionality (emissions reductions)
Хүлэмжийн хийн ялгарлыг ямар ч тохиолдолд нэмэлт байдлаар бууруулж байгаа төслийн үйл ажиллагаанд зөвхөн шагнал байдлаар олгодог нүүрстөрөгчийн кредитэд Киотогийн протокол болон сайн дурын зах зээлийн стандартын дагуу тавьдаг шаардлага.
- 278 **Нэмэлт мод, сөөг тарих**
Complement, infilling [inter planting, reinforcement planting]
Байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамал тарих.

279 **Нэн ховор ургамал**
Very rare plant

Тухайн нутаг дэвсгэрт нэн ховор тохиолддог, ареал үүсгэдэггүй, нөөцгүй ургамал.

280 **Нягт шоометр**
Solid volume of wood

Нэг шоометр орон зайг (хурааж өрсөн мод хооронд хоосон зайгүй) бүрэн дүүргэн эзэлж буй модлогийн хэмжээ.

О

281 **Огтлогдох модны эзлэхүүн**
Fellings

Өгөгдсөн хугацаанд (жишээ нь жил бүр) ойгоос огтлох эсвэл үлдээх эсэхээс үл шалтгаалан цээжний өндрийн холтостой диаметр нь 10 см-ээс дээш амьд ба хатсан бүх модны дундаж эзлэхүүн. Үүнд ойн аж ахуй, арчилгаа, цэвэрлэгээний огтлолтын үед үлдээсэн, цээжний өндөрт 10 см-ээс илүү диаметртэй модод, түүнчлэн цээжний өндөрт 10 см-ээс илүү диаметртэй байгалийн жамаар унаж буй модод бас орно.

282 **Огтлолтын нас**
Cutting age

Үндсэн ашиглалтын огтлолт хийж болох болц гүйцсэн ойн нас.

283 **Огтлолтын өмнөх сэргэн ургалт**
Advance reproduction [advance growth]

Мод огтлохын өмнөх ой модны титэм доорх ойн сэргэн ургалт.

- 284 **Огтлолтын чиглэл**
Direction of cutting
Дараачийн мод бэлтгэх талбай нь өмнө мод огтолсон талбайн аль талд нь байрлахыг харуулсан чиг. Дараачийн мод бэлтгэх талбайг ихэвчлэн салхины эсрэг чигт авдаг.
- 285 **Огтлох модыг сонгох**
Selection of trees to be removed
Түүвэрлэх, аажим болон бусад огтлолтын үед огтлох модыг тодорхой шинж тэмдгээр нь сонгох.
- 286 **Ой ашиглалт**
Forest [timber] exploitation
Ой модны янз бүрийн бүтээгдэхүүн ба ашигтай зүйлийг хүн ам, аж ахуйн хэрэгцээг хангах зорилгоор ойг ашиглах.
- 287 **Ой ашиглалтын төрөл**
Form of forest exploitation [form of forest management]
Ой модны үүрэг, ашигтай шинж чанар, тодорхой бүтээгдэхүүнээр ой ашиглалтыг нэгтгэж байгаа ангилалын нэгжүүд. Тайлбар: модлог бэлтгэх, давирхай бэлтгэх зэргээр ой ашиглалтын төрлийг ялгадаг.
- 288 **Ой ашиглалтын хэлбэр**
Type of forest [timber, wood] exploitation [type of forest management]

Ой ашиглалтын тодорхой төрлийг сонгон авах ба борлуулах эрхийн хэлбэр. Тайлбар: түрээслэх, өр төлөөсгүй ашиглах, концесс, богино хугацаагаар ашиглах зэргээр ой ашиглалтын хэлбэрийг ялгадаг.

289 **Ой зохион байгуулалт**

Forest management [forest inventory]

Ойн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүний хэмжээ, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судлан тогтоож, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагаа.

290 **Ой мод (ой)**

Forest

Ойн мод болон бусад ургамал, амьтан, бичил организм зэрэг амьд бүлгэмдэл, хөрс шороо, уур амьсгал зэрэг амьгүй орчны харилцан нөлөөлөл бүхий цогц нэгдлээс бүрдсэн экосистем. Монгол орны ой зохион байгуулалтын практикт 0.3-аас дээш өтгөрөлтэй моддыг ой модоор бүрхэгдсэн талбайд оруулдаг.

НҮБ-ийн ХХАА Байгууллагаас 2005 онд гаргасан тодорхойлолтоор ой мод нь “эзэлж байгаа талбай нь 0.5 га-аас дээш, титмийн бүрхэц нь 10 хувиас илүү, 5 метрээс өндөр модтой, эсвэл байгалийн орчиндоо энэ хэмжээнд хүрч ургах бололцоотой мод бүхий газар” юм. Хөдөө аж ахуй, хот, суурингийн байнгын ашиглалтанд байгаа газрыг энд оруулахгүй. Ойн мод нь байгалийн орчиндоо хамгийн багаар 5 м өндөрт хүрч ургах ёстой. Одоогоор дээр заасан хэмжээнд хүрээгүй боловч модны титмийн бүрхэц нь 10 хувь, өндөр нь 5 метр хүрэх бололцоотой ойжуулсан талбай болон хүн ба байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр түр зуур ойгүй болсон, цаашид нөхөн сэргэх талбайг ойн талбайд оруулна. Титмийн бүрхэц, өндөр нь таарсан далдуу ба хулсан ой, ойн зам, түймэр зогсоох зурвас болон бусад задгай газар, үндэсний парк, байгалийн нөөц газар, шинжлэх ухаан, судалгаа шинжилгээ, түүх, соёлын зориулалттай бусад тусгай хамгаалалттай газрын ой мод, 20 м-ээс илүү өргөн, 0.5 га-аас илүү талбайтай хамгаалалтын ойн зурвас, хонгил, түүнчлэн каучук модны плантац, үйсний царсан ой зэрэг ойн аж ахуй, хамгаалалын зориулалттай плантацууд мөн ойн талбайд багтана¹¹.

291 **Ой модноос хамааралтай төрөл зүйл**
Forest-dependent species

Амьдралынхаа мөчлөгийн нэг үеийг ч ой модноос гадна өнгөрөөж чадахгүй зүйл.

292 **Ой модны экологийн үүрэг ач холбогдол**
Ecological functions of forest

Хүрээлэн буй орчны хүчин зүйлс, байгаль, хүн-байгалийн гаралтай үзэгдэл, үйл явцыг хадгалах, үгүй болгох, өөрчлөх ба шинээр бий болгох, сулруулах юм уу нэмэгдүүлэхэд ой модны гүйцэтгэх үүрэг.

Ой модны экологийн үүрэг ач холбогдлыг ус, хөрс хамгаалах, уур амьсгал зөөлрүүлэх, эрүүл ахуй болон бусад гэж ангилна.

293 **Ой сайжруулалт**
Forest improvement

Ой модны бүтээгдэхүүн бий болгох, үйлчилгээ үзүүлэх чадварыг дээшлүүлэх үйл явц.

294 **Ой судлал [ой зүй]**
Forest science [forest ecology]

Ойн байгалийн төрх, биологи, экологи, орон зай ба цаг хугацааны хөдлөл зүй, зүй тогтлын тухай шинжлэх ухаан.

295 **Ой ургамалжилтын мужлал**
Forest-vegetation zoning

Ой үүсгэгч модны тархац, ойн хэв шинж, бүтэц, бүрэлдэхүүн, бүтээмж ба тэдгээр дэх ойн нөхөн сэргэлтийн үйл явцыг нөхцөлдүүлэгч байгалийн нөхцөлөөр ялгаатай хэсгүүдэд ой модны нутаг дэвсгэрийн хуваагдах байдал.

- 296 **Ой үржүүлэг**
Afforestation
Сүүлийн 50 жилийн хугацаанд ой модгүй байсан газар мод тарих, үр цацах юм уу ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжих зэрэг хүний шууд нөлөөгөөр ой мод буй болгох үйл ажиллагаа. Ойн тухай хуулинд “Урьд өмнө ой байгаагүй газар ой ургуулахыг” мод үржүүлэг гэж тодорхойлсон.
- 297 **Ой үүсгэгч модлог үүлдэр (мод)**
Main tree species [stand forming tree species]
Ургах орчны тохиромжтой нөхцөлд шигүү модод үүсгэх чадвартай модлог үүлдэр.
- 298 **Ой хамгаалагч**
Forester [ranger, manager]
Ойг сахин хамгаалагч, хууль дүрмийн биелэлтэд хяналт тавьдаг төрийн үйлчилгээний ажилтан.
- 299 **Ой хамгааллын мэргэжилтэн**
Fire fighter
Тухайн нутаг дэвсгэрийг харьяалж, түймрээс хамгаалах ажлыг гардан удирдах, мэргэжлийн ойн боловсрол эзэмшсэн улсын ой хамгааллын ажилтан.
- 300 **Ойг амралтын зориулалтаар ашиглах**
Recreation forest use
Амралт, сувилал, гоозүйн зориулалтаар ой модыг ашиглах.
- 301 **Ойг сайжруулах мод тарилт**
Enrichment planting

Хамгийн зохимжтой (өөрөөр хэлбэл, нутгийн зүйл буюу өндөр үнэ цэнтэй) модлог үүлдэр зонхилсон өндөр ашигтай ой мод ургуулах зорилгоор өөрчлөлтөд орсон байгалийн ой, орлож ургасан ой болон бусад модтой газарт шаардлагатай төрөл, зүйлийн мод тарих.

302 **Ойг тарьж нөхөн сэргээх**

Artificial reforestation [reforestation]

Урд нь ойгоор бүрхмэл байсан талбай дээр таримал ой мод буй болгох.

303 **Ойг түймрээс хамгаалах**

Fire protection [forest fire control]

Ойн сангийн ургамлан нөмрөг түймэрт өртөх, гэмтэхийн эсрэг чиглэгдсэн дэс дараатай арга хэмжээ.

304 **Ойгоор бүрхэгдсэн талбай**

Closed forest area

Титэм нийлсэн модтой (0.3-аас дээш өтгөрөлтэй) ойн талбай.

305 **Ойгоор бүрхэгдээгүй талбай**

Unforested area

Модгүй болон титэм нийлээгүй сийрэг модтой ойн талбай. Ойгоор бүрхэгдээгүй талбайд мод бэлтгэсэн, шатсан, сийрэг модтой, нүцгэрсэн ойн талбай, ойн цоорхой зэрэг урьд нь ой мод байсан газар орно.

306 **Ойжуулалт**

Reforestation

Ой модгүй болсон талбайд үр, тарьц, суулгац материал тарьж таримал ой бий болгох үйл явц.

307 **Ойжуулах мужлал**
Silvicultural zoning

Улсын бүх нутаг дэвсгэр болон түүний бүс нутгийг таримал ой модны тодорхой хэв шинжийг бий болгох шаардлагатай ба хөрс-уур амьсгалын нөхцөлөөр ижил хэсгүүдэд хуваах байдал.

308 **Ойжуулах талбай**
Area to be reforested

Таримал ой мод буй болгоход зориулсан хэсэг газар.

309 **Ойжуулах талбайг бэлтгэх**
Soil cultivation for forest plantation

Таримал ой буй болгоход зориулж хөрс бэлтгэх ба дараа дараачийн агротехникийн арга хэмжээнд шаардагдах нөхцөлийг буй болгох.

310 **Ойжуулах талбайн бүлэг**
Category of reforestation site

Өөрийн гарал үүсэл ба төлөв байдлаар нэг жигд ойжуулах талбайн бүлэг.

311 **Ойжуулах талбайн сан**
Totality of reforestation site

Ойжуулах талбайн нийлбэр цогц (бүх талбай).

312 **Ойн агаарын эргүүл**
Aerial fire patrol

Хамгаалалттай нутагт нисэх хэрэгслийг ашиглан түймэр илрүүлэх эргүүлийн тогтмол нислэг.

313 **Ойн аж ахуй**

Silviculture

Ойг хамгаалах, сайжруулах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх технологи, арга, онол.

314 **Ойн аж ахуйн салбар**

Forestry

Ой модыг үржүүлэх, хамгаалах, хадгалах, ашиглах, нөхөн сэргээх болон ойн нөөцийг судлах, тогтоох, удирдан зохицуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг салбар.

315 **Ойн аж ахуйн систем**

Silvicultural system

Ой модны оршин тогтнох бүтэн цикл ба тусгай үе шатыг хамарсан, тодорхой байгаль ба эдийн засгийн нөхцөлд нийцсэн харилцан холбоо уялдаатай ойн аж ахуйн арга хэмжээний цогц.

316 **Ойн аж ахуйн түүвэрлэх огтлолт**

Selective cutting [selection felling]

Ойн ус хөрс хамгаалах, орчин бүрдүүлэх ач холбогдлыг хадгалж мод ашиглах зорилгоор эхний ээлжинд гэмтэл, согогтой, хөгшин, өсөлт удааширсан модыг огтолж авдаг түүвэрлэх огтлолт. Моддын нөөцийн 10-30 хувийг 10-25 жилийн давтамжтай огтолно.

317 **Ойн амьдрах чадвар**

Viability of forest

Өөрийн өсөлт, хөгжилтийн явцад ой модны ургаж, амьдрах чадвар.

318 **Ойн анги**

Forest [ranger] district division of forestry

Орон нутгийн засаг захиргааны удирдлагын бүрэлдэхүүн болон ойн аж ахуйн бүрэлдэхүүнд багтдаг, нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн анхдагч нэгж.

319 **Ойн арчилгаа**

Care of stands [cleaning cutting]

Ойн модны бүрэлдэхүүн, чанар, эрүүл ахуйг сайжруулах, ойн тогтвортой байдал, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ.

320 **Ойн байгалийн сийрэгжилт**

Natural thinning [self thinning]

Ой моддын нас нэмэгдэхийн хэрээр байгалийн аясаар модны тоо хорогдох үйл явц.

321 **Ойн байгалийн сэргэн ургалт**

Natural forest regeneration

Байгалийн замаар ой нөхөн ургах явц.

322 **Ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжих**

Assistance of natural regeneration

Модыг огтлохоос өмнө ба огтолсны дараа, мод огтлох үед, тэрчилэн мод огтлохтой холбоогүйгээр ойн байгалийн нөхөн ургалтыг амжилттай болгохын тулд хэрэгжүүлж буй нэн тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн ойн аж ахуйн арга хэмжээ.

323 **Ойн биологийн олон янз байдал**
Forest biodiversity

Ой, мод, ургамлын зүйл, генетик, экосистемийн олон хэлбэршил.

324 **Ойн биомасс**
Forest biomass

Модлог ургамлын газрын гадарга дээрх бүх биомасс гэж ихэвчлэн ойлгодог.

325 **Ойн бонитет**
Site index

Ойн ургах орчны чанар, өсөлт, хөгжилтийн нөхцөл, улмаар ойн бүтээмжийг илэрхийлсэн таксацын үзүүлэлт. Ойн бонитетийг моддын үндсэн ташингын дундаж өндөр, насаар тодорхойлж бонитетийн ангиар илэрхийлнэ.

326 **Ойн бус талбай**
Non forest land

Ойн сангийн бүрэлдэхүүнд ордог ойн бус эдэлбэр газар (хадлан, бэлчээр, уулын цагаан энгэр, ус - нуур, цөөрөм г.м.), тусгай зориулалтын талбай (зам, түймрийн шороон зурвас, халз зурвас г.м.), ашиглах боломжгүй талбай (намаг, элс, таг, царам, хад асга г.м.).

327 **Ойн бүлэг хэв шинж**
Group forest type

Ойн ангилалын үндсэн нэг нэгж бөгөөд зонхилох сөөг, өвслөг ургамал, хөвд, хагаар ялгардаг бүлэг хэв шинжийн ой.

- 328 **Ойн бүрхэвчийн зураг**
Forest cover map
Агаар сансрын мэдээнд тайлал хийж гаргасан ойн бүрхэвчийн зураг.
- 329 **Ойн бүс**
Forest zone [category]
Ойн аж ахуй, ой ашиглалтын зохих горимыг тогтоох үүднээс экологи, нийгэм-эдийн засгийн ач холбогдол, байршил, гүйцэтгэж байгаа үүргээр нь ой модыг ялгаж ангилсан бүлэг.
- 330 **Ойн дагалдах сэргэн ургалт**
Attendant reproduction
Мод огтлох явцад үүссэн ойн байгалийн нөхөн ургалт.
- 331 **Ойн дагалт нөөц***
Non-wood forest resources
Ойн сангийн газар ургадаг, жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвх зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялаг.
- 332 **Ойн доройтол**
Forest degradation
Сөрөг нөлөөллийн улмаас ойн бүтэц, үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, түүний улмаас ойн үйлчилгээ үзүүлэх болон бүтээгдэхүүнээр хангах чадвар буурна.
- 333 **Ойн доройтсон газар**
Degraded forest land

Мод бэлтгэл, ойн модон бус бүтээгдэхүүний зохисгүй ашиглалт, олон удаагийн давтан түймэр, мал бэлчээрлэлт, бусад сүйтгэгч хүчин зүйлс, газар ашиглалтын улмаас хөрс, ургамал эвдэрч, ойн нөхөн сэргэлт удаан хугацаанд саатаж, доройтолд орсон газар¹⁵.

334 **Ойн завсрын ашиглалт**
Periodic stand depletion

Завсрын ашиглалтын огтлолтын үед хэрэгжүүлж буй модлог бэлтгэл.

335 **Ойн зах, хаяа**
Border of forest

Ойгүй газартай хил залгаж байгаа ой модноос 100 м хүртэл өргөн хаяа.

336 **Ойн менежмент**
Forest management

Ойн үйлчилгээг тогтвортой байлгахын тулд урт хугацааны зорилт, төлөвлөсөн үйл ажиллагаанд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээг явуулдаг ойн аж ахуйн нэг салбар.

337 **Ойн менежментийн нэгж талбай**
Forest management unit area

Урт хугацааны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан тодорхой зорилтуудыг хэрэгжүүлж менежмент хийх зориулалттай ойн талбай.

338 **Ойн менежментийн төлөвлөгөө***
Forest management plan

Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар тодорхой үе шаттайгаар тусгаж төлөвлөсөн баримт бичиг.

- 339 **Ойн модон бус бүтээгдэхүүн**
Non timber forest products (NTFP's)
Ойд үүсэн бүрэлдэж буй модноос бусад аливаа бүтээгдэхүүн юм уу үйлчилгээ.
- 340 **Ойн мониторинг**
Forest monitoring
Ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, ойн тогтвортой байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх, хадгалах арга хэмжээг үр ашигтай удирдан зохион байгуулах зорилгоор ойн төлөв байдал, хөдлөл зүйг ажиглаж, мэдээлэл цуглуулах, үнэлэх, цаашдын хандлагыг тодорхойлох тогтолцоо.
- 341 **Ойн мэдээллийн сан***
Forest databank
Ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ зэрэг үзүүлэлтийг багтаасан цогц мэдээлэл.
- 342 **Ойн нас**
Stand age
Ойг бүрэлдүүлж байгаа моддын дундаж нас.
- 343 **Ойн нөөц ашигласны төлбөр**
Payment for forest resources use

Тодорхой цаг хугацаанд ойн нөөцийг ашигласны төлбөр хийсэн баримт.

344 **Ойн нөөц, баялаг**

Forest resources

Ойн сангийн газарт байгаа мод болон модлог бус бүтээгдэхүүний нөөц хэмжээ.

Тайлбар: Ойн тухай Монгол улсын хуулинд зааснаар “ой санг талбай, ургаа модны эзлэхүүнээр илэрхийлснийг” ойн нөөц гэж үздэг.

345 **Ойн нөөцийн жилийн өсөлт**

Annual growth [forest crop]

Ойн моддын нас нэмэгдэхийн хэрээр ойн моддын нөөц сүүлийн нэг жилд өөрчлөгдсөн хэмжээ. Модны нөөцийн жилийн өсөлтийг (ΔM_1) дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$\Delta M_1 = M_A - M_{A-1},$$

M_A - А настай ойн нөөц,

M_{A-1} - 1 жилийн өмнөх ойн моддын нөөц.

346 **Ойн нөхөн сэргэлт**

Rehabilitation of forest

Ой үүсгэгч модны сэргэн ургалтын явцад ойн бүх бүрэлдэхүүн хэсэг нөхөн сэргэх үйл явц.

347 **Ойн нөхөрлөл***

Forest local communities

Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилгоор зохион байгуулж, үйл ажиллагаа явуулж буй иргэдийн сайн дурын байгууллага.

348 **Ойн нүүрстөрөгч**

Forest carbon

Газрын дээрх болон газрын доорх биомасс, үхсэн мод, хөвхөн давхарга, хөрсний нүүрстөрөгч гэсэн ойн экосистемийн нүүрстөрөгчийн таван нөөц санд хуримтлагдсан нүүрстөрөгчийн нийлбэр.

349 **Ойн нүүрстөрөгчийн нөөц**

Forest carbon stock

Тодорхой цаг хугацаанд ойн талбайд агуулагдаж байгаа нүүрстөрөгчийн тоон хэмжээ.

350 **Ойн нүүрстөрөгчийн нөөцийг нэмэгдүүлэх**

Enhancement of forest carbon stocks

Мод тарьж модны биомассын шинэ өсөлт бий болгон, нүүрстөрөгчийн нөөцийг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээ бөгөөд REDD+ийн үндсэн таван үйл ажиллагааны нэг болно.

351 **Ойн нүүрстөрөгчийн нөөцийг хадгалах Conservation of forest carbon stocks**

Ойн хомсдол ба доройтолын аюул занал учраагүй боловч нүүрстөрөгчийн нөөцийг хадгалж, хамгаалах талаар хэрэгжүүлдэг бодлого, арга хэмжээ бөгөөд REDD+ийн таван үндсэн үйл ажиллагааны нэг болно.

352 **Ойн нүцгэрсэн талбай [ойжих талбай]**

Barren area

Ойн аж ахуйн зөвшөөрөгдсөн хугацаанд (10 жил) ойн сэргэн ургаагүй хуучин мод бэлтгэсэн, шатсан болон бусад шалтгаанаар модгүй болсон их хэмжээний талбай.

353 **Ойн орломол төрөл**
Secondary forest type

Шилмүүст модны ургаж байсан газарт түр хугацаанд ургасан навчит ой ба ойн төрөл.

354 **Ойн өөрчлөлтийн зураг**
Forest change detection map

Өөр өөр цаг хугацааны мэдээг харьцуулж ойн бүрхэвчийн өөрчлөлтийг гаргасан сэдэвчилсэн зураг.

355 **Ойн сан [Монгол улсын ойн сан]***
State forest land [forest fund]

Монгол улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойн талбай. Ойн сан нь ойн болон ойн бус талбайгаас бүрдэнэ.

356 **Ойн сангийн талбай**
Total area of forest land

Ойн сангийн бүрэлдэхүүнд ордог бүх ойн болон ойн бус талбай.

357 **Ойн сонирхогч [оролцогч] талууд**
Forest stakeholders

Тухайн ойгоос шууд ба шууд бус байдлаар хамааралтай хувь болон бүлэг хүн, сонирхлын бүлэг.

358 **Ойн сэргэн ургалт**
Forest regeneration

Ойн талбай дээр ой модны шинэ үе удам үүсэх.

359 **Ойн таксац**

Forest mensuration [cruise, cruising, forest estimation]

1. Ойн нөөцийг судлан тооцож, чанарын ба тоон үзүүлэлтийг тогтоох, үнэлэх техник үйл ажиллагаа.
2. Ойн нөөцийг тооцох, үнэлэх арга, техникийг судалдаг ойн шинжлэх ухааны салбар.

360 **Ойн талаарх бодлогын баримт бичиг**

Forest policy statement

Ойн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг.

361 **Ойн талаарх бодлого**

Forest policy

Модны нөөц, ой хамгаалал, ашиглалт, менежменттэй уялдсан алс ирээдүйн шийдвэр гаргахын тулд тухайн улс орны нийгэм-эдийн засаг, байгаль орчны үндэсний бодлоготой зохицуулан төрийн байгууллагаас нийгмийн төлөө авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зарчим, чиг хандлагын нийлбэр цогц.

362 **Ойн талбай**

Forest area

Ойн модоор бүрхэгдсэн болон бүрхэгдээгүй боловч урьд нь ой мод байсан, цаашид ой ургуулах зориулалт бүхий талбай.

363 **Ойн тасархайтал**
Forest fragmentation

Байгалийн хөндөгдөөгүй унаган ой олон хэсэг болж хуваагдахад хүргэдэг үйл явц. Энэ нь биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж, үлдсэн ойн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг.

364 **Ойн титмийн бүрхэц**
Canopy cover

Ойн талбайн модны титмээр бүрхэгдсэн гадаргын хувь хэмжээ.

365 **Ойн тогтворт байдал**
Stability of forest

Тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа сөрөг хүчин зүйлсийн нөлөөллөөр үүссэн байгалийн тодорхой хэлбэлзэл, хөдлөл зүйн явцад ой мод өөрийн үүрэг ач холбогдол, гол шинж чанараа алдахгүй хадгалж байх чадвар.

366 **Ойн тогтвортой менежмент**
Sustainable forest management

Дэлхийн болон улс орон, орон нутгийн түвшинд одоо ба ирээдүйд эдийн засаг, экологи, нийгмийн хүрээнд ойн гүйцэтгэх үүрэг, биологийн төрөл зүйлүүд, бүтээмж, нөхөн сэргэлтийн чадамж, амьдрах чадварыг хадгалах замаар бусад экосистемд хор нөлөөгүйгээр ой мод болон ой бүхий газрыг ашиглах, зохицуулах үйл ажиллагаа юм.

367 **Ойн төлөв байдал**
State of forest

Байгалийн үзэгдэл, ашиглалтын объект болдогийн хувьд тодорхой цаг хугацаа ба орон зайд ойн гүйцэтгэж байгаа үүрэг ач холбогдол, гол шинж төлвийн илрэх байдал. Ойн төлөв байдлыг экологи, ойн аж ахуй, бусад олон цогц үзүүлэлтээр үнэлнэ.

368 **Ойн тухай хууль, тогтоомж**

Law and act on forest

Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт, менежмент, хэрэглээг зохицуулж байдаг, хууль тогтоох болон төрийн захиргааны холбогдох байгууллагаас баталсан хууль, тогтоомжийн нийлбэр цогц.

369 **Ойн түймрийн аюулгүйн дүрэм**

Fire safety rules

Тухайн нутгийн ойн сангийн талбайд оршин байгаа болон үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, бүх байгууллага зайлшгүй мэдэх шаардлагатай засгийн газрын баталсан журам.

370 **Ойн түймрийн баг**

Fire fighting crew

Ойн түймэр унтраах зориулалттай техник, хэрэгсэл, зохион байгуулалтыг урьдчилан хангасан бүлэг хүн.

371 **Ойн түймрийн стратеги**

Forest fire strategy

Ойг түймрээс хамгаалах хэтийн төлөвлөгөө.

372 **Ойн түймрийн тактик**

Forest fire tactics

Түймрийг дарж устгах үеийн үйл ажиллагааны дэ дараалал ба түймэр унтраах хүн хүч, багаж хэрэгслийг тараан байрлуулах үйл ажиллагаа.

373 **Ойн түймрийн үр дагавар**
Consequence of fire

Түймрийн нөхцөл, байдалтай уялдан ойн санд гарсан үзэгдэл.

374 **Ойн түймрийн эргүүл**
Fire chaser [patrol man]

Ой бүхий нутагт хийгдэх автомашин ба морин эргүүлээр тодорхой маршрут, тогтоосон цаг хугацаанд түймрийг илрүүлэхээр хийх явуулын ажиглалт.

375 **Ойн түймэр**
Forest fire

Ойн сангийн талбайд ургаж байгаа ургамлан нөмрөгт гал түймэр гарч, ойн талбай шатах үзэгдэл.

376 **Ойн түймэр гарах давтамж**
Fire occurrence

Түймрийн аюултай улиралд 100 мян/га ойн талбайд оногдох түймрийн дундаж тоо.

377 **Ойн ургамал бүлгэмдэл**
Forest plant community

Тухайн ойд ургаж байгаа модод, өсвөр мод, сөөг, хөрсний амьд нөмрөгийн нийлбэр цогц (ярианы хэлэнд ойн ургамал бүлгэмдлийг голдуу ой гэж хэлдэг).

378 **Ойн ургамалжилт**
Forest vegetation

Мод, түүнчлэн сөөг, сөөгөнцөр, өвслөг болон бусад (хаг, хөвд г.м.) ургамлаас бүрдсэн ургамалжилтын хэв шинж.

379 **Ойн ургах орчны нөхцөл**
Growing condition

Ой модны ургах орчныг тодорхойлогч ус, хөрс, уур амьсгалын хүчин зүйлсийн цогц бүрдэл.

380 **Ойн үндсэн ашиглалт**
Final cutting

Үндсэн ашиглалтын огтлолтын журмаар хэрэгжүүлж байгаа мод бэлтгэл.

381 **Ойн үндсэн хэв шинж**
Native forest type

Ургах орчны харьцангуй тогтвортой, тодорхой хэв шинжийн нөхцөлд байгалийн жамаар хамгийн сайн зохицож бүрэлдсэн ойн хэв шинж.

382 **Ойн үндэсний хөтөлбөр**
National forest programme (NFP)

Улс орны болон бүс нутгийн түвшинд ойн бодлого боловсруулж, төлөвлөж хэрэгжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээний чиг хандлага, арга хэмжээг тусгасан ерөнхий төлөвлөгөө.

383 **Ойн үрийн сэргэн ургалт**
Regeneration by natural seeding

Модны үрнээс ойн залуу үе удам үүсэх ойн нөхөн ургалтын хэлбэр.

- 384 **Ойн хана**
Side [wall of stand] of stand
Мод бэлтгэсэн талбайтай хил залгаж, модны үр тархах эх үүсвэр, ойн аж ахуй-экологийн бусад үүрэг гүйцэтгэж байдаг ойн хана.
- 385 **Ойн хоёрдогч нөөц баялгийн ашиглалт**
Use of secondary forest resources
Техник, хүнс, тэжээл, эм, хамгаалалт, экологийн нөөц баялаг, ашиглалт.
- 386 **Ойн хомсдол**
Deforestation
Хүний шууд үйл ажиллагааны улмаас ойн талбай ойн бус талбай болж хувирах.
- 387 **Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нэмэлт үйл ажиллагаа-REDD+ REDD plus (additional activities in reducing emissions from deforestation and forest degradation)**
Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах (REDD+)-аас гадна ойн тогтвортой менежмент, ойжуулалт, нүүрстөрөгчийн нөөцийг хадгалах зэрэг нэмж хэрэгжүүлдэг үйл ажиллагаа.
- 388 **Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах (REDD+) үндэсний стратеги (ОХДҮХХЯБҮС)**
National REDD+ strategy (NRS)

Энэ нь Канкуны хэлцээрийн дагуу улс орнуудад боловсруулах шаардлагатай REDD+ийн дөрвөн элементийн нэг юм. Холбогдох оролцогч талууд, нутгийн уугуул иргэд, орон нутгийнхны үр дүнтэй бүрэн оролцоог хангаж, ойн хомсдол, доройтлыг үүсгэгч хүчин зүйлс, газар өмчлөл, ойн засаглал, жэндэрийн асуудал болон аюулгүй байдлын талаар анхаарч ажиллахыг улс орнуудаас шаарддаг.

389 **Ойн хомсдолоос сэргийлэх**

Avoided deforestation

Бодлого, санхүүжилт, үйл ажиллагаа, зорилгод өөрчлөлт хийх зэргээр холбогдох арга хэмжээ авч ойн хомсдолоос сэргийлэхийг хэлнэ.

390 **Ойн хосолмол сэргэн ургалт**

Combination regeneration

Нэг талбай дээр байгалийн ба зохиомол (тарих) нөхөн ургалт нэг зэрэг болох үйл ажиллагаа.

391 **Ойн хөнөөлт шавж**

Forest pest and insects

Амьд модны янз бүрийн хэсгээр хооллож, ургаа ой модны амьдралд физиологи, техникийн хор хөнөөл учруулдаг амьтад.

392 **Ойн хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшин/ойн суурь түвшин**

Forest reference emission levels/forest reference levels

Ойн нөөцийг сайжруулах, хадгалж хамгаалах арга хэмжээний үр ашгийг үнэлэхэд ашигладаг, тухайн улс орны ойн нөөцийн хэмжээ, төлөв байдлыг тодорхойлдог хяналтын суурь үзүүлэлт.

393 **Ойн хүнсний нөөц баялгийн ашиглалт**
Use of forest food resources

Шууд ба аж ахуйн бусад арга хэмжээг зохион байгуулах замаар ойн хүнсний бүтээгдэхүүнийг цуглуулах ба бэлтгэх.

394 **Ойн хэв шинж**
Forest type

Ойн моддын төрлийн бүрэлдэхүүн, доод ташинга, хөрсөн бүрхүүлийн ургамалжилт, амьтны аймаг, ой-ургамалжилтын нөхцөлийн тодорхой хэв шинжээр тодорхойлогддог ойн аж ахуйн ангиллын төрөл⁷.

Экологийн нэг ижил нөхцөлд ургаж байгаа, олон жилийн турш харьцангуй тогтвортой байдаг тодорхой ургамлын зүйлийн бүрэлдэхүүнтэй, нэг ижил бүтэцтэй байгалийн мод, ургамлын бүлгэмдэл¹⁴.

395 **Ойн хэв шинжийн судлал**
Forest typology [forest type science]

Ойн хэв шинжийн тухай сургаал юм. Ойн хэв шинжийн ангилал ба ойн аж ахуйн байгаль-түүхийн үндэс болох ой ургамалжилтын нөхцөлийн хэв шинжийг ялгах, оношлох асуудлыг боловсруулдаг ой судлалын үндсэн хэсэг.

396 **Ойн цоорхой**
Gap

Модгүй боловч ойн ургамалжилтын шинж төрх бүхий бага хэмжээний ойн талбай.

- 397 **Ойн чөлөө**
Forest meadow [glade]
Ойн дунд байрласан өвслөг ургамалтай ойн бус талбай.
- 398 **Ойн шавж**
Forest insects
Ойд амьдардаг бүх шавж.
- 399 **Ойн шатамхай байдал [зэрэг]**
Fire category
Хамгаалагдсан нутаг дээр хуанлийн тодорхой жилд гарсан ойн түймэр, шатсан талбайг тухайн нутаг дэвсгэрийн бүх ойн талбайтай харьцуулан хувиар илэрхийлсэн үзүүлэлт.
- 400 **Ойн шатах материал**
Forest fuel [combustible material]
Шатамхай шинж чанартай ойн ургамал тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд (өвслөг ба сөөг ургамал, ойн хөвх, хөрсний хүлэрлэг давхраа, модны иш, холтос, үндэс, нарийн мөчир, шилмүүс, навч зэрэг)
- 401 **Ойн шатсан талбай**
Burnt – over forest [burned-out, fire-damaged forest]
Ургаа модод бүрэн үхсэн ойн шатсан талбай.
- 402 **Ойн шилжилтийн муруй**
Forest transition curve

Ойн шилжилт нь ой мод ойн бус эдэлбэр газар болж хувирах, цаг хугацааны явцад зарим хэсэг нь буцаад ой мод болох зэрэг голдуу улсын хэмжээнд гарч байгаа газар ашиглалтын өөрчлөлтийг тайлбарлах онолд хамаарна. Улс орны ойн бүрхэвчийн орон зай, цаг хугацааны өөрчлөлтийг ойн шилжилтийн муруйгаар илэрхийлдэг. Ойн шилжилтийг үүсгэж байгаа хүчин зүйлүүдэд эдийн засаг, технологи, хүн ам зүйн чиг хандлага болон тухайн улс орны улс төр, нийгмийн нөхцөлийн өөрчлөлтүүд орно.

403 **Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ***

Forest ecological and economic value

Ойн нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний экологи-эдийн засгийн үр өгөөжийг мөнгөн хэлбэрээр илэрхийлсэн үнэлгээ.

404 **Ойрхог байдал**

Percentage of forest land

Нутаг дэвсгэрийн ойжсон байдлын зэрэг хэмжээ. Ой модоор бүрхмэл талбайг нийт талбайд харьцуулж тодорхойлон хувиар илэрхийлнэ.

405 **Ойрын нил улаан туяаны муж**

Near infrared

0,7-1,5 мкм урттай цахилгаан соронзон долгион.

406 **Ойт хээр**

Forest-steppe

Байгалийн ой мод хээртэй хил залгадаг бүс.

407 **Ойт царам**

Forest-tundra

Дэлхийн бөмбөрцгийн хойт хагасын субарктикийн бүслүүрийн ойн ба цармын хоорон дахь шилжилтийн байгалийн бүс.

408 **Олон сувгийн мэдээ**
Multispectral data

Цахилгаан соронзон долгионы өөр өөр мужид авсан тоон мэдээ.

409 **Олон талт үр ашиг**
Multiple benefits

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанаас урган гарах шууд ба дам үр ашиг. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулсан нэмэлт үр ашиг болно.

410 **Олон улсын зөвлөгөө, дүн шинжилгээ**
International consultation and analysis

Хоёр жил тутмын тайланд техникийн экспертүүдийн багаар техникийн дүн шинжилгээ хийлгэж, үр дүнг талуудад тайлагнан, мэдээллийг хуваалцах талаар НҮБ/УАӨСК-ийн нарийн бичгийн дарга нарын газраас зохион байгуулдаг үйл ажиллагаа.

411 **Олшруулах мод тарилт**
Enrichment planting

Ихэвчлэн доройтсон ойд одоо байгаа модны нягтралыг нэмэгдүүлэх эсвэл модны төрөл зүйлийн тоог өсгөхийн тулд мод тарих үйл явц.

412 **Онгон ой**
Virgin forest

Аж ахуйн болон хүний үйл ажиллагаанд өртөөгүй, ой үүсгэгч модлог үүлдэр олон үе удмын турш зөвхөн байгалийн үйл явцын нөлөөн дор оршиж, өөрчлөгдөж байдаг уугуул нутгийн байгалийн ой мод. Хүний нөлөө тун бага, зарим модыг огтолсон байж болно.

413 **Оптик муж**
Optical range

Цахилгаан соронзон долгионы 0,3 мкм -15 мкм хоорондын зурвас муж.

414 **Орлож ургасан ой**
Secondary forest

Үндсэн ой мод нь гэмтэж, сүйдсэний дараа орлож ургасан, үүсэн бүрэлдэх эцсийн шатанд (климакс ой) бүрэн гүйцэд хүрээгүй ой. Гадаад сөрөг хүчин зүйлсийн нөлөөгөөр шилмүүс ой нь ихэвчлэн орлож ургасан навчит ой модоор солигддог.

415 **Оройн түймэр**
Crown fire

Ойн ургамлан бүлгэмдлийн бүх ташинга шатаж, модны титмээр гал дамждаг түймэр.

416 **Оролцогч тал**
Stakeholder

Төсөлд оролцож байгаа, оролцох албан ёсны эрхтэй, сонирхолтой, эсвэл эрх ашиг нь хөндөгдөж болох хувь болон бүлэг хүн, байгууллага.

417 **Орон зайн бага шийдтэй зураг**
Low resolution image

Орон зайн шийд 1км-ээс бага зураг.

418 **Орон зайн дунд шийдтэй зураг**
Medium resolution image

Орон зайн шийд 10м – 60м хүртэлх зураг.

419 **Орон зайн дүн шинжилгээ**
Spatial analysis

Агаар, сансрын мэдээнд тайлал хийж бусад вектор мэдээтэй давхцуулан дүн шинжилгээ хийх арга.

420 **Орон зайн загвар**
Spatial model

Олон талт мэдээнд дүн шинжилгээ хийж гаргасан бүтээгдэхүүн.

421 **Орон зайн мэдээ**
Spatial data

Аливаа объектийн гадарга дээрх байршлын тухай тодорхой координатын системд оруулсан мэдээ.

422 **Орон зайн өндөр шийдтэй зураг**
High resolution image

Орон зайн шийд 0,60м-5м хүртэлх зураг.

423 **Орон нутгийн түвшин**
Subnational

REDD+ хөтөлбөрийг улсын нийт нутаг дэвсгэрээс бага хэмжээний нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх.

424 **Орон зайн шийд**
Spatial resolution

Сансрын зургийн ялгах чадвар.

Ө

- 425 **Өвлийн мөчрийн тайрдас**
Winter stem cutting
Өвлийн тайван байдал дахь үеийн ургамлын модожсон мөчрөөс бэлтгэсэн тайрдас.
- 426 **Өгөгдлийн (анхны) тухай мэдээ**
Metadata
Тухайн өгөгдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.
- 427 **Өгөгдөл**
Data
Аливаа хэмжилт болон судалгааны анхдагч баримт мэдээ.
- 428 **Өмчийн эрх ба өмчийн эрх эзэмшигч Property rights and property rights holders**
“Өмчийн эрх”-ийг газар, нутаг дэвсгэр, нөөцийг эзэмших, ашиглах, хүртэх, зохион байгуулах хууль ёсны болон хэвшсэн эрх хэмээн тодорхойлдог бөгөөд “Өмчийн эрхийн эзэмшигч/өмчлөгч нар” нь тэдгээр өмчийн эрхийг дангаар болон хамтдаа эдэлнэ.
- 429 **Өндөг (шавж)**
Eggs
Шавжийн хөгжлийн эхний шат.
- 430 **Өндөр ба давжаа модыг сийрэгжүүлэх арчилгааны огтлолтын арга**
Free thinning

Залуу ойд ургаж байгаа өндөр ба давжаа модыг зэрэг сийрүүлж, модны байршил, шигүүг тохируулдаг арчилгааны огтлолтын арга.

431 **Өндөр модыг сийрэгжүүлэх арчилгааны огтлолтын арга**

Crown thinning [high thinning]

Моддын ташингын дээд хэсэгт байгаа сайн чанарын үндсэн модны өсөлтийг сайжруулах зорилгоор өндөр ургасан навчит болон зарим том хэмжээний үндсэн шилмүүст модыг сийрүүлж авдаг арчилгааны огтлолтын арга. Энэ аргыг голдуу холимог ойд хэрэглэнэ.

432 **Өндрийн тоон загвар**
Digital elevation model

3 хэмжээст огторгуйд дүрс байгуулах загвар.

433 **Өргөн талбайгаар хавтгайруулсан огтлолт**
Clear cutting with artificial regeneration

Их хэмжээтэй мод бэлтгэх талбайд хийдэг хавтгайруулсан огтлолт. Мод бэлтгэх талбайн өргөн нь 500 (1000) м хүрнэ.

434 **Өсвөр мод**
Understory trees [young growth, undershrub, undergrowth, regrowth]

Эх ой моддыг халж, ойн модны 1-р ташингад орох чадвартай ой доторх ба мод огтолсон талбай дээрх модлог ургамлын залуу үе удам.

435 **Өсөлт**
Increment

Ой, модны нас ахихын хэрээр түүний хэлбэр хэмжээ (өндөр, диаметр, хөндлөн огтлолын талбай, эзлэхүүн г.м.) нэмэгдэх үзэгдэл.

П

436 **Панхроматик зураг**
Panchromatic image

Үзэгдэх гэрлийн болон ойрын хил улаан туяаны мужийн зарим хэсгийг оролцуулан авсан хар цагаан зураг.

437 **Пиксел**
Pixel

Сансрын зургийн нарийвчлалыг илэрхийлэх нэгж.

438 **Плотер**
Plotter

Зургийг том форматаар хэвлэх төхөөрөмж.

439 **Популяцийн олшролын үе шат (шавж)**
Phases of population increase

Шавжны популяцийн тоо, чанарын үндсэн үзүүлэлтээр тодорхойлогдсон хугацаа.

440 **Популяцийн олшролын хөдлөл зүй (шавж)**
Population dynamics

Шавжны популяцийн олшролын үргэлжлэх хугацаа, хөдлөл зүй.

441 **Проекц буюу тусгаг**
Projection

Газар дээрх объектийн байршлыг заасан утга.

P

- 442 **Радар**
Radar
Хиймэл дагуулаас цацруулсан долгионыг гадаргаас буцаж сарнихад бүртгэдэг төхөөрөмж.
- 443 **Радарын долгион**
Radar wave
Радарын тандан судалгаанд ашигладаг 0,75см-1м урттай долгион.
- 444 **Радиометрийн засал**
Radiometric correction
Сансрын мэдээний тодролын өөрчлөлтийг засах арга.
- 445 **REDD+ үйл ажиллагаа**
REDD+ activity
REDD+д хүлээн зөвшөөрөгдсөн REDD+ийн таван үйл ажиллагаа хамрагдана. Үүнд: ойн хомсдолоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн нүүрстөрөгчийн нөөцийг хамгаалах, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, ойн нүүрстөрөгчийн нөөцийг нэмэгдүүлэх.

C

- 446 **Саад бэрхшээл**
Barrier

REDD+ийн хувьд саад бэрхшээл гэдэг нь REDD+ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тохиолдож болзошгүй урьдчилан сэргийлэх шаардлагатай ямар нэг зүйл. Энэ нь бодлого болон мэдлэг хийгээд нөөцийн хомсдол байж болно.

447 **Сааруулах (уур амьсгалын өөрчлөлт)**
Mitigation (climate change)

Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд хүний үйл ажиллагааны улмаас агаар мандалд цацагдсан хүлэмжийн хийн хэмжээг бууруулахад чиглэсэн аливаа нэг үйл ажиллагаа.

448 **Сайн дурын үйл ажиллагаа**
Voluntary action

Албан бус хөтөлбөр, бие даасан үүрэг мэдэгдэл.

449 **Сайн чанартай мод**
Desirable trees

Чанарын үзүүлэлт, төлөв байдлаараа аж ахуйн зорилгод хамгийн сайн тохирсон, голдуу үндсэн үүлдрийн мод.

450 **Салхинд унах (мод)**
Blowdown

Мод салхинд үндсээрээ ховхорч унах.

451 **Салхинд хугарах (мод)**
Windthrow

Салхинд модны иш, орой хугарах.

452 **Сансрын зураг**
Satellite image

Хиймэл дагуулаас авсан дүрс зураг.

453 **Сансрын зураг боловсруулалт**

Image processing

Агаар, сансрын янз бүрийн түвшингээс авсан дүрс зургийн гажилт, тодролыг сайжруулан засах арга.

454 **Сансрын зургийн ангилал**

Image classification

Аливаа биет, юмс, үзэгдлийг ямарваа нэгэн ижил төстэй шинж тэмдгээр нь ялгах арга.

455 **Сансрын зургийн тайлал**

Image interpretation

Агаар сансрын мэдээнд гар тайлал, автомат тайлал хийж сэдэвчилсэн мэдээг гарган авах арга.

456 **Сенсор**

Sensor

Хиймэл дагуул дээр суурилуулсан долгионыг бүртгэж хэмждэг төхөөрөмж.

457 **Сийрүүлэх огтлолт**

Thinning [improvement cutting]

Ойн үндсэн үүлдрийн модны шигүүрлийг зохицуулж, өсөлтийг сайжруулахын тулд насны III ангийн залуу ойд хийдэг арчилгааны огтлолт. Энэ огтлолтоор хэлбэр муутай, согогтой модыг голчлон огтлоно.

458 **Сийрэг шоо метр**

Stocked content [stocked volume]

Нэг шоометр орон зайд хураасан модлогийн хэмжээ. Сийрэг шоо метрийг түлээний модонд хэрэглэнэ. Хураасан түлээний өргөн, урт өндрийг үржүүлж сийрэг шоо метрийг тодорхойлно.

459 **Сонгомол идэшт (шавж)**

Oligophagous

Цөөн төрөл зүйлээр сонгон хооллодог шавж.

460 **Сортимент**

Assortment [length, log, section, shortwood]

Стандарт, техникийн нөхцөлд нийцэж байгаа, тусгай зориулалтын боловсруулсан ба боловсруулаагүй модон материал.

461 **Сөөг**

Shrub

Гол ишгүй, ихэвчлэн хөрсний гадарга орчмоос эхлэн мөчирлөсөн, их өндөр ургадаггүй олон наст модлог ургамал. Сөөг нь голдуу 0.6-6.0 м өндөр ургана.

462 **Сөөгний түймэр**

Bush fire

Сөөгөн ширэнгийг хамран шатах ургамлын түймэр.

463 **Сөөгөн ташинга**

Shrub layer

Ой дотор ургаж байгаа ташинга үүсгэсэн бүх төрлийн сөөг, түүнчлэн тухайн ургах орчны нөхцөлд ойн моддын бүрэлдэхүүнд орж, ой үүсгэх чадваргүй давжаа ургасан зарим мод.

- 464 **Сөөгөнцөр**
Undershrub [lowshrub]
Голдуу их мөчирлөсөн, хэдэн жил болоод хатаж унадаг модожсон иштэй намхан ургамал. Сөөгөнцөр нь 0.6-0.8 м хүрдэг.
- 465 **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ (дээр дурдсан Канкуны сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээг үз)**
Safeguards (see also Cancun safeguards above)
Сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ гэдэг нь байгаль орчин, нийгэм болон бусад зүйлд хор хөнөөл / хохирол/ учруулахгүй байх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм.
- 466 **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (CHCMC)**
Safeguards information system (SIS)
CHCMC нь улс орнууд REDD+ийг хэрэгжүүлэх бүх хугацаанд сөрөг нөлөөллөөс сэргийлэх долоон зарчмыг хэрхэн үзэж, биелүүлж байгаа тухай мэдээллээр хангадаг тогтолцоо юм.
- 467 **Спектрийн ойлт**
Spectral reflectance
Байгаль дээрх юмс, үзэгдлээс ойсон цахилгаан соронзон долгион.
- 468 **Спектрийн шийд**
Spectral resolution
Сансрын мэдээг бүртгэсэн сувгийн тоо.

469 **СПОТ-ын мэдээ**
SPOT data

Францын Сансрын үндэсний төв, Бельги, Шведтэй хамтран бүтээж 1986 онд хөөргөсөн СПОТ дагуулын мэдээ. Орон зайн шийд 2,5м, 5м, 10м.

470 **Суваг**
Band

Цахилгаан соронзон долгионы муж.

471 **Суурь үзүүлэлтийн хувилбар**
Baseline scenario

REDD+ийн хувьд REDD+ үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй үед ирээдүйд хүлээгдэж буй хүлэмжийн хийн ялгарлын байж болох хувилбарууд.

472 **Сүүдэрсэг шилмүүст ой**
Dark coniferous forest

Гацуур, жодоо, хуш зэрэг сүүдэрт тэсвэртэй шилмүүст модлог үүлдэр зонхилсон ой мод.

473 **Сэдэвчилсэн зураг**
Thematic map

Байгалийн нөөц баялаг, биет юмс, үзэгдэл, объектын гадарга дээрх байршлыг харуулсан зураг.

Т

474 **Таарамжгүй мод**
Undesirable trees

Сайн чанартай болон туслах модны өсөлт, чанарт сөрөг нөлөөлдэг, тухайн экологийн нөхцөл, эдийн засгийн зорилгод таарч нийцэхгүй мод.

- 475 **Тайрдас**
Branch cutting [shoot cutting]
Ургал эрхтнээр ургуулах зорилготой нэг-хоёр настай ургамлын хэсэг эрхтэн.
- 476 **Тайрдасны суулгац**
Cutting nurseling [cutting transplant]
Тайрдаснаас ургуулсан суулгац.
- 477 **Тайрдасны суулгац бойжуулах талбай**
Trial area of cutting transplant of nursery
Мод үржүүлгийн газрын талбайн тайрдасны суулгацыг ургуулахад зориулан тусгаарласан хэсэг.
- 478 **Талууд**
Party
НҮБ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ хүлээн зөвшөөрч, гэрээ хүчин төгөлдөр болсон улс орнууд эсвэл бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (жишээ нь Европын холбоо).
- 479 **Талуудын Бага Хурал (ТБХ)**
Conference of the Parties (COP)
НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх суурь конвенцид гарын үсэг зурсан улс орнуудын байнга хийдэг хурал.
- 480 **Тандан судалгааны хэрэглээ**
Remote sensing applications

Байгаль орчны төлөв байдал, байгалийн нөөц баялгийг судлах, уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын мэдээ гаргах болон байгалийн бусад үзэгдлийг урьдчилан тогтооход ашиглана.

481 **Таримал ой**

Artificial [homogeneous, man-made] stands; [forest cultures, forest plantation]

Нутгийн болон нутгийн биш төрөл зүйлийн модны тарьц ба үр тарьж ургуулсан, мөн согдуулаар (өмнө нь тарьсан модны хожуул, үндэсний дагавар ба унтмал нахиа) ургаж үүссэн бөгөөд нэг, хоёр ба хэд хэдэн төрөл зүйлийн ижил насны мод адил зайд ургасан таримал ой¹⁴.

482 **Таримал ой буй болгох арга**

Method of forest planting

Гараар юм уу эсвэл механик хэрэгслээр ойжуулалтын ажил гүйцэтгэх цогц арга.

483 **Таримал ой буй болгох төсөл**

Project of forest culture

Тодорхой талбай дээр таримал ой буй болгох технологи ба ой-ургах орчны нөхцөлийн тодорхойлолтыг агуулсан баримт бичиг.

484 **Таримал ойг ойгоор бүрхэгдсэн талбайд**

шилжүүлэх

Inclusion of forest plantation in covered forest area

Өсөлт, төлөв байдлаар тоо, чанарын тодорхой үзүүлэлтүүдэд хүрсэн таримал мод, сөөгийн талбайг ойгоор бүрхэгдсэн талбайд оруулах.

- 485 **Таримал ойг хүлээн авах техник арга ажиллагаа**
Technical procedure of forest culture
Тарьц, үрээр ойжуулсан ажлын чанар, бодит хэмжээ ба таримал ой буй болгох төсөл төлөвлөгөөтэй тэдгээрийг хэрхэн нийцэж буйг тогтоох арга ажиллагаа.
- 486 **Таримал ойн амьдралт**
Conservation of forest plantation
Амьдрах чадвартай таримал ойн талбайг тодорхой хугацааны турш тарьсан нийт таримал ойн талбайд харьцуулан хувиар илэрхийлсэн үзүүлэлт.
Тайлбар. Ойгоор бүрхэгдсэн талбайд шилжүүлэх үед 25 хувиас дээш амьдралттай, цаашдаа ойн өсөлтийн явцын хүснэгт, стандартын норм-техникийн баримт бичгийн шаардлагад нийцэх бололцоотой таримал ойг амьдрах чадвартай ойд тооцно.
- 487 **Таримал ойн арчилгааны агротехник**
Agrotechnical tending of forest culture
Хөрсийг сийрүүлэх, хог ургамлыг устгах, хөвх ба навчин хучаасыг зайлуулах, бордох замаар тарималжуулж буй мод, сөөгний өсөлт ба амьдралтыг сайжруулахад чиглэсэн иж бүрэн арга ажиллагаа.
- 488 **Таримал ойн бүртгэл-тооллого**
Inventory of forest culture
Газар дээр нь судлах замаар таримал ойн ургаж байгаа эсэх, тэдгээрийн талбай, төлөв байдал, талбайг тодорхойлох.
- 489 **Таримал ойн нас**
Age of forest plantation

Таримал ой модыг буй болгосон цаг хугацаанаас хойш улиран өнгөрсөн жилийн тоо.

490 **Таримал ойн шигүүрэл**

Density of forest culture

Таримал мод, сөөгний нэгж талбай дахь тоо.

491 **Тармаг ой**

Open [sparsely, understocked] stand [light forest]

Сийрэг модтой, 0.3-аас доош өтгөрөлтэй ойн талбай.

492 **Тархалтын голомт (шавж)**

Distribution area

Шавжийн тархалтын голомт.

493 **Тарьсан мод нутагших чадамж**

Capacity for survival [survival rate] of forest culture

Тарьсны дараа ургаж байгаа мод, сөөгний тоог анх тарьсан юм уу хүлээн авах актын дагуу тарих ёстой мод, сөөгний нийт тоонд харьцуулан хувиар илэрхийлсэн үзүүлэлт.

494 **Техникийн ургамал**

Industrial plants [industrial crops]

Үйлдвэрлэлийн түүхий эд өгдөг байгалийн ба таримал ургамал.

495 **Техникийн хортон шавж**

Wood borers

Модны хэрэглээний чанарыг алдагдуулдаг шавж.

496 **Технологи дамжуулах**

Technology transfer

Янз бүрийн оролцогч талуудын дунд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицоход зориулсан ноу-хау, туршлага, тоног төхөөрөмжийг хамарсан өргөн хүрээний олон талт үйл ажиллагаа.

497 **Титмийн бүрхэц**

Crown cover

Ойн талбайн модны титмээр бүрхэгдсэн гадаргын хувь хэмжээ. Үүнийг бас ойн титмийн бүрхэц буюу модны бүрхэц гэж нэрлэдэг.

498 **Титэм**

Crown (tree) [leafage]

Олон мөчрөөс бүрэлдсэн модны дээд хэсэг. Титэмд навч, шилмүүс, цэцэг, үр жимс үүснэ.

499 **Титэм нийлсэн ой мод (ой)**

Closed forest

Янз бүрийн ташинга болон ойн титэм дор ургаж байгаа мод нь газрын ихээхэн (40 % -иас дээш) хувийг бүрхсэн, үргэлжилсэн, шигүү өвслөг нөмрөггүй ургамалжилтын хэвшил. Дотор нь менежменттэй ба менежментгүй ой, үндсэн ой, сэргэн ургалтын дэвшилт төлөвд байгаа ой, нэг ба хэд хэдэн удаа огтолсон ч ойн үндсэн шинжээ хадгалж үлдсэн болон бүтэц бүрэлдэхүүн нь өөрчлөгдсөн ой гэх мэт ангилдаг.

500 **Тогтвортой хөгжил**

Sustainable development

Тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй үеийнхнийхээ хэрэгцээгээ хангах чадвар боломжийг нь боогдуулахгүйгээр өнөө үеийнхний хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн хөгжил (Брундтландын комисс).

501 **Тогтмол байдал (хүлэмжийн хийн бууралт)**
Permanence (emissions reductions)

Тогтмол байдал гэдэг нь хүлэмжийн хийн бууралтыг тогтмол байлгахад зориулан авч буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ болон ирээдүйд ялгарч болох нүүрстөрөгчийг шингээх боломжийг баталгаатай болгоход тавигдах шаардлага.

502 **Тогтонги түймэр**
Steady fire [stable fire]

Түймрийн галын хөвөө 0,5 м/мин ба түүнээс бага дундаж хурдтай тархаж байгаа түймэр.

503 **Тодорхойгүй байдал**
Uncertainty

Үнэлгээ, утга нь мэдэгдэхгүй байх түвшингийн илэрхийлэл.

504 **Тодорхойгүй түймэр**
Being investigated fire

Байрлал, шинж байдал нь тодорхой биш түймэр.

505 **Тоймчилсон судалгаа (шавж)**
Reconnaissance surveillance

Суурь судалгаанд үндэслэсэн шавжны тархалт, хөнөөлийн голомтын талбайг тогтоох, тэмцлийн арга хэмжээг тодорхойлох судалгааны арга.

506 **Тооны өсөлтийн үе (шавж)**

Prodrome phase

Шавжийн олшролын үе.

507 **Тохируулах огтлолт**

Cleaning [liberation cut]

Ойн үндсэн үүлдрийн модны шигүүрлийг зохицуулж, өсөлтийг сайжруулахын тулд насны II ангийн залуу ойд хийдэг арчилгааны огтлолт. Үндсэн үүлдрийн модны өсөлтөд саад болж байгаа навчит мод төдийгүй өсөлтөөр муу болон шигүү ургасан бүлэг модны дотор бусаддаа саад болж байгаа үндсэн үүлдрийн зарим модыг огтолно.

508 **Төрийн бус байгууллага**

Non-governmental organizations (NGOs)

Төрийн бус байгууллага (ТББ) гэдэг нь төрийн байгууллагаас бусад ашгийн бус байгууллага.

509 **Тусгай хамгаалалттай газар**

Protected area

Биологийн олон янз байдал, байгаль, түүнтэй холбоотой соёлын нөөцийг хамгаалах, хадгалах, хууль эрхзүй болон бусад үр дүнтэй аргаар менежмент хийдэг тусгай зорилго бүхий хуурай газар, далай тэнгисийн нутаг дэвсгэр.

510 **Туслах мод**

Subsidiary trees

Сайн чанартай модны өсөлт, чанарыг сайжруулж, ус-хөрс хамгаалах, хөрс сайжруулах болон экологийн бусад үүрэг гүйцэтгэдэг, ойн бүрэн бүтэн, тогтвортой байдлыг хадгалах ач холбогдолтой мод.

511 **Тууш мод**

Tree length

Ёзоороос орой хүртэл мөчир, гишүүг цэвэрлэсэн, унагасан модны иш.

512 **Тухайн үеийн өсөлт**

Current annual increment

Сүүлийн нэг жил юм уу эсвэл тухайлж авсан хэд хэдэн жил ба ой модны насны бүх хугацаанд гарсан бодит өсөлт.

513 **Тухайн үеийн түймрийн аюул**

Short term fire danger [current fire danger]

Тухайн цаг үеийн хувьд тодохойлогдох цаг уурын нөхцөлийг тусгасан түймрийн аюулын төлөв байдал.

514 **Түймрийг бүрэн унтраах**

Moopping up

Түймэр гарсан талбай дээрх уугисан гал, шаталтын голомтыг дарж, түймрийг бүрэн гүйцээж унтраах үе шат.

515 **Түймрийг бүслэх**

To corral a fire

Нэгж хугацаанд түймрийн бүх захыг хүрээлж унтраах тактик.

- 516 **Түймрийг илрүүлэх**
Fire detection[discovery]
Гарсан түймрийг илрүүлэх, тухайн түймрийн байрлал, голомтыг олж тогтоох үйл ажиллагаа.
- 517 **Түймрийг илрүүлэх үе**
Fire detection time [discovery time]
Түймэр гарч эхэлсэнээс хойш түүнийг илрүүлэх хүргэлх цаг, хугацаа.
- 518 **Түймрийг хязгаарлан тогтоох**
Fire localization
Түймэр тархахыг зогсооход чиглэсэн түймэр унтраах үе шат.
- 519 **Түймрийн ажиглалтын байр**
Fire lookout point
Түймрийг илрүүлэх зорилгоор хамгаалсан нутаг, дэвсгэрийг системтэйгээр харж болох газар дээр байгуулсан ажиглалтын байр.
- 520 **Түймрийн ажиглалтын цамхаг**
Fire lookout tower
Түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан даруйд шуурхай илрүүлэх, ажиглахаар тоноглон ажиглалтын цамхаг.
- 521 **Түймрийн ар тал**
Rear of fire
Түймрийн фронтын эсрэг талын галын хөвөө, тактикийн хэсэг.

- 522 **Түймрийн аюул**
Fire danger
Түймэр гарах магадлалаар илэрхийлэгдсэн түймэр үүсэх аюул, занал.
- 523 **Түймрийн аюултай улирал**
Fire season
Олон жилийн ажиглалтын явцад тухайн нутаг, дэвсгэр дээр ургамалжилтын түймэр гарах магадлалтай улирал.
- 524 **Түймрийн аюулыг тодорхойлох**
Fire-danger measurement
Түймрийн аюулын хэмжээ, шинж чанарыг олдог хэмжилт ба тооцоололтын нэгдмэл үйл ажиллагаа.
- 525 **Түймрийн аюулыг хэмжигч**
Danger meter [burning-index meter]
Түймрийн аюулыг хэмжих зориулалттай багаж.
- 526 **Түймрийн аюулын анги**
Fire danger class
Түймрийн аюулыг тоон үнэлгээгээр илэрхийлсэн, түймрийн аливаа аюулын зэргийн хэсэг.
- 527 **Түймрийн аюулын урьдчилсан мэдээ**
Fire-danger forecasting [fire hazard forecast]
Цаг агаарын хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн цаг уурын үзүүлэлтээр гаргасан түймрийн аюулын урьдчилсан мэдээ.
- 528 **Түймрийн аюулын хэмнүүр**
Burning index [fire hazard index]

Цаг агаарын нөхцөлөөр түймрийн аюулын харьцангуй төлөв байдлыг илэрхийлсэн хэмжээгүй үзүүлэлт.

529 **Түймрийн багаж төхөөрөмж**
Fire equipment

Ойн санг түймрээс хамгаалахад хэрэглэдэг техник, багаж төхөөрөмж.

530 **Түймрийн байршлыг тодорхойлох**
Detection of fire

Түймэр гарсан газрыг баримжаалж гаргах буюу координатыг зураг дээр тогтоож, түймрийн байрлалыг тодорхойлох үйл ажиллагаа.

531 **Түймрийн галын хөвөө**
Fire edge [fire line, fire margin]

Түймрийн үед үндсэн шатамхай материал шатаж, дээд хэмжээгээр дулаан ялгарч, тасралтгүй тэлж байгаа галын зурвас.

532 **Түймрийн давтамжийн зураг**
Fire occurrence map

Олон жилийн хугацаанд гарсан түймрийн байршлыг тэмдэглэсэн газрын зураг.

533 **Түймрийн дараах унанги**
Fire slash [debris]

Түймрийн нөлөөгөөр хугарч, булгарч унасан модод.

534 **Түймрийн зориулалттай хүрз**
Shovel [spade]

Сул ба дунд эрчимтэй гадаргуугийн түймрийн галын дөл рүү шороо цацах, нарийн зурвас гаргах зэрэгт хэрэглэх түймрийн гар багаж.

535 **Түймрийн манаач, сахиул**

Fire spotter [towerman, fire guard, observer]

Ойн санд түймрийг илрүүлэх, унтраахаар ажиллаж байгаа ой хамгааллын улирлын ажилчин.

536 **Түймрийн масс**

Mass fire

Нэг зэрэг олон гал дүрэлзсэн түймэр. Энэхүү түймэр нь их энерги гаргадаг.

537 **Түймрийн менежмент**

Fire management

Ойн үнэ цэнт шатамхай зүйлсийг түймрээс хамгаалах болон түймрийг газрын менежментийн зорилгод ашиглахад чиглэгдсэн бүх үйл ажиллагаа.

538 **Түймрийн периметр**

Fire perimeter

Түймрийн хөвөөний гадаад хилийн урт.

539 **Түймрийн солбицол**

Fire location

Түймрийн ажиглалтын хоёр ба түүнээс дээш цэгээс өнцөг хэмжигч багажийг ашиглан түймэр гарч байгаа газрын байршлыг тодорхойлох.

540 **Түймрийн сорви**

Fire scar [fire wound]

Түймрийн нөлөөгөөр модны ишний модлогийн хэсэгт үүссэн золумын гэмтэл.

541 **Түймрийн талбай**

Burned area

Түймрийг дарж устгах төгсгөлийн үед тодорхой болсон түймрийн талбай.

542 **Түймрийн гармуур**

Fire rake

Хусах зориулалт бүхий шүдтэй, урт иштэй багаж бөгөөд хөнгөн шатах материалыг татаж зайлуулах, хөрсний өнгөн хэсгийг хуулж унтраах зэрэгт хэрэглэгдэнэ.

543 **Түймрийн тархалтыг зогсоох**

Being held [shut-down] of fire speed

Түймрийн тархалтыг зогсоож түймэр унтраах үе шат.

544 **Түймрийн тархалтыг хязгаарлах байгалийн саад**

Natural-fire break [fuel break]

Тухайн газар, нутаг дээрх түймрийн тархалтыг хязгаарлахад ашиглаж болох байгалийн тогтоц (нуур, гол, цөөрөм, намаг, уулын хяр).

545 **Түймрийн тархалтыг хязгаарлах ойн зааг зурвас**

Cut – off [forest fire prevention ride]

Ойн түймрийн тархалтыг хориглох зорилгоор ой дотор 4-6 м өргөнтэй мод огтолж гаргасан зааг зурвас.

546 **Түймрийн тархалтын хурд**

Speed of fire spread

Түймрийн талбай нэмэгдэх хурд.

547 **Түймрийн төрөл**

Character of fire [fire class, fire type]

Шаталтын тархацын шинж, үндсэн шатах материал зэргээрээ ижил, төсөөтэй түймрүүдийг нэгтгэсэн түймрийг ангилах ангилалын нэгж.

548 **Түймрийн төрх байдал**

Fire behaviour

Түймрийн эрч хүчээ авах ба тархах онцлог.

549 **Түймрийн фронт [түймрийн нүүр тал]**

Head of fire [fire front]

Нэг минутаас багагүй хугацаагаар тодорхойлогдох хамгийн их дундаж хурдтайгаар урагшлах түймрийн хөвөөний тактикийн хэсэг.

550 **Түймрийн хажуу [жигүүр]**

Flanks of a fire

Түймрийн фронтын хөдөлгөөний дунд чиглэлд хөндлөн тэрчилэн энэ чиглэлтэй зэрэгцэн урагшлах түймрийн захын тактикийн хэсгүүд.

551 **Түймрийн харлалт [бад]**

Singeing [scorching]

Гадаргуугийн түймрийн нөлөөгөөр модны ишний гадаргууд үүссэн харлалт.

552 **Түймрийн хоногийн аюултай цаг үе**

Burning period [daily burning period]

Тухайн хоногт түймрийн эрчим, тархалтын хурд их, түймэр гарах хамгийн их магадлалтай цаг.

553 **Түймрийн хохирол**

Fire damage [harm, injury]

Түймрийн сөрөг үр дагаварын шууд ба дам нөлөөг дундаж үзүүлэлтээр тооцож гаргасан мөнгөн илэрхийлэл.

554 **Түймрийн хошуу**

Fingers of fire

Түймрийн тойруу хэлбэр дүрснээс хамгийн урт хошуурсан зурвас.

555 **Түймрийн хүрээ**

Fire contour [outline]

Түймрийн хөвөөний гадаад хилийг битүү холбоход үүссэн дүрс.

556 **Түймрийн цохиур**

Fire beater

Төмөр, резин дэвүүр, зузаан даавуу, тааран шуудай зэрэг материалыг толгойн хэсэгт нь бэхэлсэн урт иштэй гал унтраах зориулалттай багаж.

557 **Түймрийн цурам**

Acreage burned

Түймрийг бүрэн устган дарж дуусах үеийн түймрийн хүрээний доторх шатанги талбай.

558 **Түймрийн шуурхай ажиллагааны зураг**

Fire progress map

Тухайн түймрийн тархалт болон түүнийг устган дарах үйл ажиллагааны тухай мэдээллийг тэмдэглэж харуулсан газрын зураг.

559 **Түймрийн эрчим**
Intensity of fire

Нэгж хугацаанд түймрийн фронтын уртын нэгжид ялгарах дулааны дундаж хэмжээ (ккал/м.сек).

560 **Түймрээс сэргийлэх арга хэмжээ**
Fire prevention

Олон нийт, газар эзэмшигчид түймэр гаргахаас сэргийлэх, түймрийн аюул, тархалтыг бууруулах зорилгоор түймрийн менежмент, ойн менежмент, ойн ашиглалтын хүрээнд авч хэрэгжүүлж буй бүхий л арга хэмжээ¹⁰.

561 **Түймрээс урьдчилан сэргийлэх арга**
Methods of fire prevention

Түймрээс урьдчилсан сэргийлэх 3 үндсэн арга байдаг. Эдгээрт 1) хууль, дүрэм журам, стандарт боловсруулах, 2) түймрийн аюулын үнэлгээ, түймэр гарах эрсдлийг тодорхойлох, түймрийн аюулыг багасгахад чиглэгдсэн хяналт шалгалт, 3) ухамсар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх зэрэг орно.

562 **Түймрээс хамгаалах зохион байгуулалтын төлөвлөгөө**
Fire control planning

Олон жилийн хугацаанд ойг хамгаалах, ойн санг түймрээс хамгаалах, сэргийлэх, зохион байгуулах ажлыг тусгасан албан баримт бичиг.

- 563 **Түймэр алсаас харагдах орон зай**
Visibility distance of fire
Тухайн нөхцөлд түймрийн утаа ялгарч үзэгдэх хамгийн хол зай.
- 564 **Түймэр гарах магадлал**
Fire risk
Хамгаалагдсан нутаг дэвсгэр дээр байгаль, хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр түймэр гарах нөхцөл бүрдэх.
- 565 **Түймэр зогсоох зурвас [түймрийн шороон зурвас]**
Firebreak
Түймрийн тархалтыг таслах, зогсоох, хянаж барих болон түймэр угтуулж гал (цурав) тавих тулгуур зурвас болгож ашигладаг байгалийн жамаар байгаа ба зориуд байгуулсан, шороон үе хүртэл ямар нэг шатамхай материалгүй болгосон (үүгээрээ шатахгүй зурвасаас ялгаатай) шороон зурвас¹⁰.
- 566 **Түймэр зогсоох шуудуу**
Fire line [fire break off]
Ойн хөрсний түймрийн тархалтыг зогсоох зорилгоор ухсан суваг.
- 567 **Түймэр рүү шууд довтлох**
Direct attack
Бүх техник хэрэгсэл, хүн хүчээр нэг хугацаанд тасралтгүй шийдвэртэй арга хэрэглэн түймрийг дарах, устгах болон түймрийн тархалтыг зогсоох, түймрийн захыг унтраахад чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа.

- 568 **Түймэр тархалтын саад [хориг]**
Fireguard
Оройн түймрийн тархалтыг зогсоох саад.
- 569 **Түймэр унтраах**
Fire suppression
Түймэр гарах үеэр шаталтыг зогсоохын тулд чиглүүлэн хийж буй үйл ажиллагаа.
- 570 **Түймэр унтраах ажлын удирдагч**
Fire warden [fire boss]
Түймрийг устган дарах үүрэг, хариуцлага, удирдлагыг өөртөө хүлээсэн ой хамгааллын ажилтан.
- 571 **Түймэр унтраах арга**
Fire fighting method
Түймрийг унтраахад бусдаас эрс ялгаатай унтраах хэрэгслийг хэрэглэх арга.
- 572 **Түймэр унтраах төлөвлөгөө**
Fire control plan [fire liquidation plan]
Түймэр унтраахад чиглэсэн тактик-техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ авч явуулах төлөвлөгөө.
- 573 **Түймэр унтраах үе шат**
Fire liquidation
Түймрийг бүрэн унтрааж, түүнийг дахин сэргээхгүй байхад чиглэсэн нэгдмэл үйл ажиллагаа.
- 574 **Түймэр эхэлсэн цэг**
Starting point of fire

Түймэр гарч улмаар тархаж эхэлсэн шаталтын анхдагч голомтын цэг.

575 **Түймэртэй тэмцэх бэлтгэл**

Fire presuppression

Түймрийг дарж, устгах боломжтой техник хэрэгсэл болон хүн хүчний бэлтгэл.

576 **Түлээний мод**

Firewood [fuelwood]

Түлшинд хэрэглэх, хуурай нэрэх, нүүрс гаргах зорилгоор модны үзүүр ёзоор, чанар муутай хэсгээс бэлтгэсэн мод болон хуурай модны тайрсан хэсэг.

577 **Түр хугацааны мод үржүүлгийн газар**

Temporary nursery

5 жилээс ихгүй хугацаагаар байгуулагдсан мод үржүүлгийн газар.

578 **Тэжээлийн ургамал**

Fodder plants

Хадсан өвс, хүчит тэжээл, өвс, хадлангийн гурил хэлбэрээр малын тэжээлд ашигладаг тэжээлийн сайн чанартай байгалийн ба таримал ургамал.

579 **Тэсвэртэй байдал**

Resilience

Эвдрэл доройтлыг тэсвэрлэж гарах системийн чадвар.

У

580 **Удаан хугацааны аажим огтлолт**

Long gradual felling

Янз бүрийн насны модтой ойд болц гүйцээгүй залуу модыг дараа огтлохоор үлдээж, болц гүйцсэн, хөгшин модыг эхний ээлжинд огтолж авдаг хоёр давтамжтай аажим огтлолт. Дараачийн огтлолтыг 30-40 жилийн дараа залуу модны болц гүйцсэн үед хийнэ.

581 **Улаан туяаны муж**

Visible red

1,57μм – 1,5мм урттай цахилгаан соронзон долгион.

582 **Улиангар**

Aspen [*Populus tremula*]

Ой үүсгэгч, 80-90 жил насалдаг, 18 м хүртэл өндөр ургадаг, диаметр нь 25 см хүрдэг, навчит мод.

583 **Улиас**

Poplar [*Populus laurifolia*]

Татмын ой үүсгэгч, 90-120 жил насалдаг. 18 м хүртэл өндөр ургадаг, диаметр 24 см хүрдэг, навчит мод.

584 **Улсын ойн сангийн бүртгэл**

Inventory of forest land

Ойн сангийн тоо, чанарын төлөв байдал, түүний өөрчлөлтийг тодорхой жилийн давтамжтай байнга тодорхойлох арга ажиллагаа.

585 **Унаган зүйл**

Endemic species

Зөвхөн тухайлсан хязгаарлагдмал газар зүйн бүс нутагт байгаа амьтан, ургамлын зүйлүүд, өөрөөр хэлбэл, тухайлсан бүс нутгаар хязгаарлагдсан зүйл.

- 586 **Унасан мод**
Deadfall [fallen timber]
Газар унасан модны иш, түүний хэсэг.
- 587 **Унаш**
Litter
Ойд шинэхэн хагдарч унасан навч, шилмүүс, нарийн найлзуур, холтос, үр, жимс, хаг, хөвд, сөөгөнцөр болон өвслөг ургамлын хөрсөн дээрх сэвсгэр үе буюу бүх амьд бус биомасс.
- 588 **Унтраах техник хэрэгсэл (гал, түймэр)**
Fire fighting equipment
Түймрийг унтраах тусгай зориулалттай техник хэрэгсэл.
- 589 **Ургаа модны борлуулах нөөц**
Commercial growing stock
Зах зээлийн тухайн нөхцөлд худалдан борлуулах болон цаашид борлуулах бүрэн боломжтой (цээжний өндөр дэх диаметр нь борлуулах боломжтой хэмжээнээс бүдүүн) ургаа модны нөөц. Үүнд орон нутаг, олон улсын зах зээлд борлуулах боломжтой модлог үүлдрийн болц гүйцсэн мод орох ба харин хууль эрх зүй, эдийн засаг болон бусад шаардлагаар мод огтлохыг хориглосон газрын ургаа модны нөөц орохгүй.
- 590 **Ургаа модны мөчир тайралт**
Pruning

Өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, түймрийн аюулыг багасгах модны чанар, яргүй хэсгийн гарцыг нэмэгдүүлэх зорилгоор модны титэм, ишний доод хэсгийн мөчир тайрах арга хэмжээ.

591 **Ургал эрхтний үүсэлтэй модод (ой)**
Coppice stand

Ургал эрхтэнээс үүссэн модод. Ийм мод нь хожуул, үндэсний согдуул (нахиа), ишний нахианаас ургана.

592 **Ургал эрхтнээр сэргэн ургах**
Regrowth [vegetative reproduction, stump planting]

Ургамлын ургал эрхтэн ба тэдгээрийн хэсгээр ойн залуу үе удам үүсэх ойн нөхөн ургалтын хэлбэр. Тайлбар: Тайрдас, үндэсний согдуул, хожуулын найлзуур, ургамлын бусад хэсгээс үүссэн залуу үе удам.

593 **Ургамалжилт**
Vegetation

Дэлхийн хуурай газрыг бүрхсэн ургамлын бүлгэмдлийн цогц нэгдэл.

594 **Ургамлан хамгаалах зурвас**
Living firebreak

Галд тэсвэртэй ургамлаар бүтээн бий болгосон хамгаалах зурвас.

595 **Ургамлан шатах материал**
Fuel plant material [surface fuel]

Тухайн тодорхой нөхцөлд мэдэгдэхүйц ижил төрлийн шинжтэй, түймэр гарахад шатах задралын зэргээрээ харилцан адилгүй ургамал ба ургамлын үлдэгдэл.

- 596 **Ургамлын ялгааны нормчлогдсон индекс**
Normalized difference of vegetation index
Ногоон ургамлын спектрийн ойлт.
- 597 **Урьдчилан сэргийлэх гал**
Prescribed burning
Түймрийн эрчмийг бууруулах ба урьдчилан сэргийлэх зорилгоор зориуд асаасан гал⁴.
- 598 **Урьдчилан сэрэмжлүүлэх зарчим**
Precautionary principle
Биологийн олон янз байдал багасах, устаж үгүй болох аюул байгаа газарт мөрдөгдөх зарчим. Шинжлэх ухааны хувьд бүрэн мэдээлэл дутмаг байх нь устах аюулаас сэргийлэх, багасгах арга хэмжээг хойш тавих шалтгаан болохгүй.
- 599 **Урьдчилан төлөвлөсөн түймэр**
Prescribed fire
Менежментийн зорилгоор тавьсан түймэр буюу тодорхой заавар зөвлөмжийн дагуу шатааж буй түймэр. Тухайлбал, нөөцийн менежментийн зорилгыг биелүүлэх, эсвэл туршилт хийхээр урьдчилан тодорхойлсон талбайд зориудаар түймэр тавьж шатах материалыг багасгах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа.
- 600 **Урьдчилгаа зээл**
Ex-ante crediting

Ялгарлын ирээдүйд буурах хэмжээнд баталгаа гарган кредит олгох (Киотогийн протоколд зөвшөөрдөггүй).

601 **Урьдчилсан тооцоолол**

Ex-ante accounting

Тухайн арга хэмжээ хэрэгжиж, ирээдүйд ялгарлын хэмжээ буурна гэдэгт баталгаа гаргаж, мөнгөн урьдчилгаа олгоход зориулан ялгарлын бууралтыг урьдчилан тооцох аргачлал.

602 **Устаж байгаа зүйл**

Critically endangered species

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны улаан номын жагсаалтын устах аюулд өртсөн зүйлийн А-аас Е ангиллын шалгуураар устаж байгаа зүйлийг заасан таксон буюу ангилал зүйн нэгж. Тиймээс энэ ангиллын зүйлийн мөхөх эрсдэл маш их.

603 **Устаж болзошгүй зүйл**

Endangered species

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны улаан номын жагсаалтын устах аюулд өртсөн зүйлийн А-аас Е ангиллын шалгуураар устаж болзошгүй зүйлийг заасан таксон буюу ангилал зүйн нэгж. Тиймээс энэ ангиллын зүйлийн мөхөх эрсдэл их.

604 **Уугуул бус зүйл**

Non-native species

Санамсаргүй эсвэл зориудаар нутагшуулсан, өөрийн байгалийн нутгаас гадна байгаа зүйл, заримдаа түүнийг содон зүйл гэдэг.

- 605 **Уугуул нутгийн зүйл**
Native species
Тодорхой орон нутаг болон онцгой экосистемд байгалиасаа оршин байгаа зүйл.
- 606 **Уулын ой**
Mountain forest
Уулын харьцангуй өндөр нь далайн түвшингээс дээш 100 метрээс илүү уулархаг газар ургаж байгаа ой мод.
- 607 **Уур амьсгалын ногоон сан (УАНС)**
Green Climate Fund (GCF)
2010 оны Канкунд болсон 16 дугаар Талуудын бага хурлаар улс орнуудын Засгийн газрууд конвенцийн 11-р зүйл дэх санхүүгийн механизмыг удирдах байгууллага болох уур амьсгалын ногоон сан (АУНС)-г байгуулсан. АУНС нь хөгжиж буй орнуудад төсөл, хөтөлбөр, бодлого, бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг дэмжинэ. Уг санг УАНС-ийн Удирдах хороо удирддаг.
- 608 **Уур амьсгалын өөрчлөлт**
Climate change
Дэлхийн уур амьсгалд хүний үйл ажиллагааны үзүүлсэн шууд нөлөөний үр дагавар.
- 609 **Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах**
Climate change mitigation
Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахын тулд хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ.

- 610 **Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулах үндэсний хувь нэмэр**
Intended nationally determined contributions (INDC)
Лимад болсон 20 дугаар ТБХ-аас хүлэмжийн хийг бууруулах замаар дэлхийн дулаарлыг хязгаарлах тухай конвенцийн зорилгод хүрэхийн тулд улс орон бүр Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад оруулах үндэсний хувь нэмрээ боловсруулан өргөн барихаар шийдвэр гаргасан.
- 611 **Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын мэргэжилтний хороо (УАӨЗГМХ)**
Intergovernmental Panel on Climate Change (IPCC)
Уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны үр дүнг шийдвэр гаргагчдад хүргэхийн тулд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Дэлхийн цаг уурын байгууллагын хамтран байгуулсан шинжлэх ухаан, техникийн байгууллага.
- 612 **Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй**
Climate change adaptation
Уур амьсгалын бодит болон болзошгүй нөлөөлөлд экологи, нийгэм, эдийн засгийн системийн хувьд хариу зохицох үйл ажиллагаа.

Ү

- 613 **Үзэгдэх гэрлийн муж**
Visible
0,4-0,7μм урттай цахилгаан соронзон долгион.
- 614 **Үйл ажиллагааны зардал**
Transaction cost

Үйл ажиллагааны зардал гэдэг нь REDD+, Ойн удирдах зөвлөл (Forest Stewardship Council-FSC) гэх мэт системд оролцох шаардлагыг биелүүлэхийн тулд гаргадаг зардал.

615 **Үйл ажиллагааны зорилго**

Performance target

Үзүүлэлтэнд хүрэх ёстой түвшин буюу бусад үр өгөөжийг хүртэхийн тулд оролцогчийн гүйцэтгэх ёстой үр дүн ба үйл ажиллагаа.

616 **Үйл ажиллагааны мэдээ (YAM)**

Activity data (AD)

Үйл ажиллагааны мэдээ нь хүний үйл ажиллагааны үр дүнд гарсан өөрчлөлтийн тоо хэмжээ. Бэлтгэж авсан модны биомасс ба огтлогдсон талбайн хэмжээ. Үүнийг ойн нүүрстөрөгчийн ялгарал юм уу шингээлтийг тооцоолоход бусад хүчин зүйлтэй хамт хүлэмжийн хийн тооллого хийхэд хэрэглэдэг.

617 **Үйл ажиллагааны хамрах хүрээ (REDD+ийн)**

Scope (REDD+)

Үйл ажиллагааны хамрах хүрээ гэдэг нь REDD+ стратеги, ойн (ялгарлын) суурь түвшинд орох ёстой REDD+ийн таван үйл ажиллагаа.

618 **Үйлдвэрлэлийн бөөрөнхий мод**

Industrial roundwood

Түлээнээс бусад бөөрөнхий мод, тухайлбал зүсмэлийн гуалин, фанерийн гуалин, модлог целлюз болон цуулбар хийх бөөрөнхий мод, бага зэрэг дөрвөлжилж зассан болон бусад хэлбэртэй (бэлтгэсэн мөчир, үндэс, хожуул г.м.) унагасан болон бэлтгэж авсан бөөрөнхий модон материал. Үүнд ой, ойн захаас огтолж авсан, түүнчлэн байгалийн жамаар болон мод огтлолтын үед унасан холтостой, холтосгүй хэрэгцээний бүх мод.

619 **Үйлдвэрлэлийн түүвэрлэх огтлолт**

Commercial selective cutting

Үйлдвэрлэлийн хэрэгцээ хангасан, болц гүйцсэн, хөгшин модыг сонгон огтолдог түүвэрлэх огтлолт. Моддын нөөцийн 30-50 хувийг 30-40 хүртэл жилийн давтамжтай огтолно.

620 **Үндсэн ашиглалтын огтлолт**

Harvest cutting [final cutting]

Мод бэлтгэх, ойг нөхөн сэргээх зорилгоор ашиглалтын бүсийн болц гүйцсэн, хөгшин ойн модыг огтолж ашиглах.

621 **Үндсэн ашиглалтын огтлолтын**

систем

Cutting [harvest] system

Ижил аргаар гүйцэтгэж байгаа мод огтлолтын хэлбэрийн нийлбэр цогц. Огтлолтын системийг хавтгайруулсан огтлолт, аажим огтлолт, түүвэрлэсэн огтлолт гэж ангилна.

622 **Үндсэн ашиглалтын огтлолтын арга**

Cutting methods

Үндсэн ашиглалтаар авах модыг огтлох арга, зарчим.
Мод огтлох үндсэн арга нь:

- Хавтгайруулан огтлох арга- нэгж талбайгаас ойн бүх модыг нэг удаа огтлох.
- Аажим огтлох арга – нэгж талбайгаас ойн модыг 2-4 удаа огтлох.
- Түүвэрлэн огтлох арга - ойн модыг бага хэмжээгээр байнга түүвэрлэн огтлох.

623 Үндсэн ашиглалтын огтлолтын хэлбэр

Type of cutting

Экологийн нөхцөлийн өөрчлөлтийн хэмжээ, ойн сэргэн ургалт, улмаар ойн үүсэн бүрэлдэхэд нөлөөлдөг огтлолтын техник-зохион байгуулалтын элементийн онцлогийг харгалзан үндсэн ашиглалтын огтлолт, аргыг дотор нь хуваасан ангиллын нэгж. Огтлолтын техник-зохион байгуулалтын элементэд мод бэлтгэх талбайн хэмжээ, өргөн, хэлбэр, чиглэл, хоёр талбайг нийлүүлэх арга, хугацаа болон бусад үзүүлэлт орно.

624 Үндсэн ашиглалтын түүвэрлэх огтлолт

Selective method

Янз бүрийн насны модтой ойд нас, хэмжээ, чанарын хувьд огтлох шаардлага хангасан модны тодорхой хувийг жил, жилийн хугацаанд байнга огтолж авдаг үндсэн ашиглалтын огтлолт. Түүвэрлэх огтлолтыг ойн аж ахуйн түүвэрлэх огтлолт, үйлдвэрлэлийн түүвэрлэх огтлолт, бүлгээр түүвэрлэх огтлолт г.м. ангилна.

625 Үндсэн модлог үүлдэр (мод)

Chief [principal tree species]

Ойн ургах орчин, эдийн засгийн тодорхой нөхцөлд экологийн шаардлага, аж ахуйн зорилгод хамгийн сайн тохирч байгаа модлог үүлдэр.

626 **Үндсэн модод (ой)**

Climax stand

Ойн үндсэн хэв шинжийн модод.

627 **Үндсэн шатах материал**

Wooden fuel

Түймэр гарах үед хамгийн их хэмжээний дулаан ялгаруулдаг ойн шатах материал.

628 **Үндэс**

Root

Навч-ишт ургамлын ургал эрхтнүүдийн нэг. Үндэс нь ургамлыг хөрсөнд бэхлэх, түүнээс ус, тэжээлийн бодисыг шингээх, хэд хэдэн шингээгдсэн бодисыг анхлан хувиргах, органик бодисыг нийлэгжүүлэх, цаашид тэдгээрийг бусад эрхтэнд дамжуулах, тэрчилэн солилцооны бүтээгдэхүүнийг ялгаруулах зэрэг үүрэг гүйцэтгэдэг.

629 **Үндэсний дасан зохицох хөтөлбөр**

National adaptation programmes (NAPAs)

Буурай хөгжилтэй улсуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохтой холбоотой шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай, тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээг тодорхойлох үйл ажиллагаа. Эдгээр арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэхгүй бол өртөмхий байдлыг нэмэгдүүлж, дараагийн шатанд зардлыг өсгөж болзошгүй.

- 630 **Үндэсний онцлогт тохирсон сааруулах арга хэмжээ**
(YOTCAH)
Nationally appropriate mitigation actions (NAMAs)
Хөгжиж буй улс орнууд Үндэсний онцлогт тохирсон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ (ҮОНХХЯБАХ)-г өөрсдийн үндэсний хөгжлийн зорилтын дагуу боловсруулахыг зөвшилцсөн. ҮОНХХЯБАХ-ний хүрээнд хөгжиж буй орнууд 2020 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг одоо байгаа хэмжээнээс бууруулахыг зорьж байна.
- 631 **Үндэсний систем**
Root system
Нэг ургамлын бүх үндэс.
- 632 **Үндэсний сөгдуул**
Rootshoot [rootstock, sprout, root stalk, sucker]
Үндэснээс үүсч гарсан залуу ургамал.
- 633 **Үндэсний тайлан-илтгэл**
National communication
Конвенц (протокол)-ийн дагуу уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хийсэн үйл ажиллагааг талууд бусад талдаа мэдээлэхээр өргөн барьдаг баримт бичиг.
- 634 **Үндэсний тайрдас**
Root cutting
Ургамлын үндэсний хэсгээс бэлтгэсэн тайрдас.
- 635 **Үндэсний хортон шавж**
Root insects
Үндсээр хооллогч шавжууд.

- 636 **Үр ашиг хуваарилах механизм**
Benefit-sharing mechanism
Янз бүрийн оролцогчид, талуудын хооронд төслийн санхүүжилтийг багтаасан төслийн үйл ажиллагааны шууд болон шууд бус үр ашгийг хуваарилахын тулд боловсруулж, хэрэглэдэг зарчим, загвар, үйл явц.
- 637 **Үр тарих норм**
Application rate [seeding rate, sowing rate norm]
1 га (кг-аар) эсвэл 1 м² тууз (далан), тарих мөрийн 1 уртааш метрт тарьж буй үрийн (гр.) жин хэмжээ.
- 638 **Үржих (ургамал)**
Propagation [reproduction]
Дээд, доод ургамлын үржих, олшрох үйл явц.
- 639 **Үрийн бүлэг мод**
Clump of seed plants [seed tree]
Мод огтолсон талбай дээр түүнийг үрээр хангах зорилгоор үлдээсэн бүлэг мод. Тайлбар: Бүлэг мод голдуу 0,01 га-аас бага хэмжээтэй.
- 640 **Үрийн гаралтай модод (ой)**
Stand originating from seed
Үрээр ургасан модод.
- 641 **Үрийн зурвас мод**
Seed lane [seed swath]
Мод огтолсон талбайг үрээр хангах зорилгоор үлдээсэн моддын зурвас.
Тайлбар: модны тэсвэртэй байдлыг хадгалах тооцоогоор зурвасны өргөн 30-50м.

- 642 **Үрийн мод**
Seed plants [seed tree]
Байгалийн үрийн нөхөн ургалтыг хангах зорилгоор ихэвчлэн мод огтлох явцад үлдэж хоцорсон сайн чанарын, сайн өсөлттэй, салхинд тэсвэртэй үрээ өгч буй модод.
- 643 **Үрийн эх үүсвэр**
Seeding-well [seeding] source
Үр өгөх үүрэг гүйцэтгэж буй ойн хана, тусгай мод ба моддын янз бүрийн бүлэг.
- 644 **Үүргэн шүршигч**
Knapsack sprayer [backpack jet, backpack sprayer]
Гал унтраах шингэнийг агуулсан үүргэвч шүршигч төхөөрөмж.
- 645 **Үхсэн мод**
Dead wood
Бүх үхсэн модны биомасс.
- 646 **Үхсэн модны биомасс**
Dead wood biomass
Хатсан босоо болон газарт унасан мод, хөвх болж хувираагүй бүх үхсэн модлогын биомасс. Үхсэн модонд хөрсний гадарга дээр унасан мод, үхмэл үндэс, 10 см юм уу тухайн оронд тогтоосон жишиг диаметрээс бүдүүн хожуулыг оруулна.
- 647 **Үхсэн модны биомассын нүүрстөрөгч**
Carbon in dead wood biomass

Хатсан босоо болон газарт унасан мод, хөвх болж хувираагүй бүх үхсэн модлогын биомассанд агуулагдаж буй нүүрстөрөгч. Үхсэн модонд хөрсний гадаргуу дээр унасан мод, үхмэл үндэс, 10 см юм уу тухайн оронд тогтоосон жишиг диаметрээс бүдүүн хожуулыг оруулна.

Ф

648 **Физиологийн хортон шавж**

Physiological pests

Модны амьдралын хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг шавж.

649 **Фитомасс**

Phytomass

Хуурай бодисын үнэмлэхүй жингийн нэгжээр голдуу илэрхийлэгддэг, нэгж талбайд ногдож байгаа ургамлын биомасс.

650 **Фотосинтез**

Photosynthesis

Ургамал нүүрс ус нийлэгжүүлэхийн тулд агаараас нүүрсхүчлийн хийг шингээж, хүчилтөрөгч ялгаруулах үйл явц.

Х

651 **Хавсралт Б-д орсон орнууд**

Annex B Countries

Хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлах, багасгах зорилтот үүрэг авсан Киотогийн Протоколд нэгдэн орсон эдийн засгийн хөгжилтэй улс орнууд.

652 **Хавтгайруулсан огтлолт**
Clear cutting (method)

Мод бэлтгэх талбай дээрх бүх модыг нэг удаа огтолж авах үндсэн ашиглалтын огтлолт. Хавтгайруулсан огтлолтыг байгалийн сэргэн ургалттай, зориудын сэргэн ургалттай, өргөн ба нарийн талбайгаар хавтгайруулсан огтлолт гэсэн хэлбэрүүдэд хуваана. Ойн тухай Монгол улсын хуулиар Монгол орны ойд хавтгайруулсан огтлолт хийхийг 1995 оноос эхлэн хориглосон.

653 **Хаг**
Lichens

Хаг доод давхаргын ургамалд хамаарагддаг, мөөг ба замагтай нягт хамтран амьдардаг цогц организм болно.

654 **Хамгаалалтын ойн бүс**
Protected forest zone

Ус, хөрс хамгаалах, эрүүл ахуй, амралт, сувилалын өндөр ач холбогдолтой, үндсэн ашиглалтын огтлолт явуулахыг хориглосон бүсийн ой мод.

Ойн хуульд хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс дээш налуу газрын ой хамаарна.

655 **Хамгаалах зурвас**
Fire-break

Гадаргуугийн түймрийн тархалтыг зогсоох зорилгоор хөрсний гадаргуу дээр гаргасан зурвас⁴.

656 **Хамгаалах үнэт зүйлстэй газар**
High conservation values area

Нэн их ач холбогдолтой юм уу онцгой хамгаалах шаардлагатай, хадгалж, хамгаалахын тулд тусгай менежмент шаарддаг байгалийн үнэт зүйлстэй нутаг.

657 **Хамруулах арга**
Nested approach

REDD+ийн төсөлд суурилсан үйл ажиллагааг улсын юм уу үндэсний REDD+ хөтөлбөрт хамруулж хэрэгжүүлэх арга.

658 **Харь зүйл**
Invasive species

Шинжлэх ухааны бүтээл, орон нутгийнханы мэдээллээр Дэлхийн харь зүйлийн мэдээллийн санд <http://www.issg.org/database>) бүртгэгдсэн тодорхой нутгийн экосистем, ургамал, амьтны амьдрах орчин ба зүйлд аюул занал учруулж байгаа уугуул бус зүйл.

659 **Хатсан мод**
Dead standing tree

Хатсан босоо мод.

660 **Хатуу модлогт навчит ой**
Hard-wood broad-leaved stand

Өргөн навчит, хатуу модлог бүхий ой.

661 **Хатуу модлогт навчит үүлдэр (мод)**
Hard-wood broad-leaved species

Хатуу модлогтой навчит үүлдэр. Үүнд царс, агч, нүцгэн ховол болон бусад мод орно.

- 662 **Хил дамнасан үйл явдал**
Trans-boundary
Ямар нэг үйл явдал бүс нутаг болон улс орны хилийг дамнан гарч байгаа нөхцөл байдал.
- 663 **Ховор ургамал**
Rare plant
Байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац нөөц багатай, устаж болзошгүй ургамал.
- 664 **Ховордсон зүйл**
Threatened species
Ховордсон зүйл гэдэг нь устаж алга болох эрсдэлтэй байгаа зүйл.
- 665 **Хоёр жил тутмын тайлан-илтгэл (ХЖТТИ)**
Biennial Update Report (BUR)
Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээ, хэрэгцээ шаардлага, авсан дэмжлэг зэргийг агуулсан, Үндэсний хүлэмжийн хийн тооллогын хамгийн сүүлчийн хувилбарыг багтаан НҮБҮАӨСК-д гаргадаг тайлан-илтгэл.
- 666 **Хоёрдогч голомт (шавж)**
Second core area
Шавжийн тоо толгой эрс нэмэгдэх үе.
- 667 **Хожуулын согдуул**
Sap shoot [stool shoots, tallage]
Хожуулаас үүсч гарсан залуу найлзуур.
- 668 **Холимог модод (ой)**
Mixed stand

Хоёр ба түүнээс олон модлог үүлдрээс бүрэлдсэн ой.

669 **Хориглох зурвас**

Fire stop [fenderstop, fire barrage]

Гадаргуугийн түймрийн хөвөөний өмнө хориг, саад хийхээр хөрсний гадаргуу дээр урьдчилан бэлтгэж гаргасан хамгаалах зурвас.

670 **Хориотой зурвасын ой***

Prohibited forest strip

Хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой хамаарна.

671 **Хөвд**

Moss

Ургамлын аймгийн нэг төрөл, дээд ургамлын салбар, олон наст намхан жижиг ургамал.

672 **Хөвд-намгийн түймэр**

Moss-peat-bog fire

Хөвдөн намаг дээр гарах ургамлын түймэр.

673 **Хөвх (ойн)**

Forest floor

Химийн хувирал, задралын янз бүрийн шатанд оршиж байгаа хагас ялзмагжсан унашнаас бүрэлдсэн ойн хөрсөн дээрх өнгөн үе.

674 **Хөвхний нүүрстөрөгч**

Carbon in litter

Эрдэс болон органик хөрсөн дээр ялзралын янз бүрийн үе шатанд оршиж байгаа, тухайн улсын тогтоосон жишиг хэмжээнээс нарийн диаметртэй бүх үхсэн модлогын биомассанд агуулагдаж буй нүүрстөрөгч. Энд унаш, хөвх, ялзмагт давхрага орохоос гадна, энгийн аргаар ялгах боломжгүй 2 мм-ээс нарийн диаметртэй амьд үндэс (эсвэл тухайн улсын тогтоосон жишиг хэмжээний диаметр бүхий газар доорх биомасс) орно.

- 675 **Хөвхний түймэр (ой)**
Litter fire [fire of debris layer, creeping]
 Ойн хөвх агуулсан үндсэн шатах материал шатдаг хөрсний түймэр.
- 676 **Хөвхөн давхарга**
Litter
 Газрын гадарга унаш, навч, жижиг үхсэн биомасс, хөрсний гадаргын ялзмагт давхаргыг хамарсан ойн нүүрстөрөгчийн нөөц сан.
- 677 **Хөгшин модод (ой)**
Declining stand [overmature stand]
 Болцын нас хүрэх үеэс хоёр ба түүнээс дээш насны ангиар илүү гарсан настай модод.
- 678 **Хөдөө аж ахуйн ээлжлэн ашиглалт**
Shifting agriculture
 Ойг юм уу шатаах, цэвэрлэгээ хийж, дараа нь хөдөө аж ахуйн үр тариа тарихаар богино хугацаагаар (1-5 жил) үлдээх арга хэмжээ.
- 679 **Хөндлөн огтлолын талбай**
Basal area

1. Ургаа модны ёзоороос дээш ишний 1.3 м буюу цээжний өндөр дэх хөндлөн огтлолын талбай.
2. Ойн бүх модны 1,3 м өндөр дэх хөндлөн огтлолын талбайг нэгж талбайд оногдох нэгжээр ($\text{м}^2/\text{га г.м.}$) илэрхийлсэн хэмжээ.

680 **Хөндлөн хаялбар**
Contour

Газрын ижил өндөртэй цэгүүдийг холбосон шугам.

681 **Хөндлөнгийн үнэлгээний тайлан**
Independent Assessment Report

Хавсралт I-д орсон талуудын олон улсын хэлэлцээрийн протокол бүрийн үнэлгээний үр дүн болох хөндлөнгийн үнэлгээний тайлан нь НҮБУАӨСК-д тайлагнах шаардлагын дагуу мэдээлэх талуудын тайлангийн нэг хэсэг болно.

682 **Хөнөөлийн голомт (шавж)**
Hotspot of forest pests

Шавжтай тэмцэл явуулбал зохих талбай.

683 **Хөрсний амьд бүрхэвч**
Field layer [ground vegetation]

Ойн модоор бүрхэгдсэн болон бүрхэгдээгүй талбайд ургаж байгаа хагас сөөг, сөөгөнцөр, өвслөг ургамал, хөрсний хөвд, хаг, мөөгнөөс бүрэлдсэн ургамлан бүрхэвч.

684 **Хөрсний органик бодис (ХОБ)**
Soil organic matter (SOM)

Газрын доорх биомассын нөөц сангийн амьд, бүдүүн (1 см-ээс дээш) үндсээс бусад хөрсөн дэх бүх органик материал бүхий нүүрстөрөгчийн нөөц сан.

685 **Хөрсний түймэр (ойн)**

Ground fire

Ойн экосистемийн хөрсний органик хэсгүүд шатахад үүсэх түймэр⁴.

Хөрсний органик хэсэг, тухайлбал хатсан намаг, хүлэрлэг, хөвхөн давхрагыг шатаадаг (үүгээрээ гадаргын түймрээс ялгаатай) түймэр¹⁰.

686 **Хувийн эзэмшил дэх газар (ой)**

Land (forest) under private ownership

Хувь хүн, өрх гэр, хувийн компани, корпораци, үйлдвэрлэл, шашны ба боловсролын байгууллагууд, тэтгэвэр, хөрөнгө оруулалтын сан ба бусад хувийн байгууллагуудын эзэмшсэн газар (ой).

687 **Хувирсан байгалийн ой**

Modified natural forest

Хүний үйл ажиллагааны мэдэгдэхүйц шинж, тэмдэг тод илэрсэн, байгалиас сэргэн ургасан уугуул нутгийн зүйлүүдээс үүссэн ой мод. Энд дараах ойг багтаах боловч нарийн хязгаар хэмжээ байхгүй: түүвэрлэх огтлолт явуулсан талбай, байгалиар сэргэн ургаж буй хөдөө аж ахуйн ашиглалтын талбай, түймрийн дараа нөхөн сэргэж буй талбай гэх мэт. Энд байгалийн болон дэмжсэн нөхөн ургалтын аль нь болохыг ялгах боломжгүй талбайнууд орно.

688 **Хус хавтага навчит**

Birch [*Betula plathyphylla*]

Ой үүсгэгч, 120 жил хүртэл насалдаг, 10-18 м өндөр ургадаг, диаметр нь 25 см хүрдэг, навчит мод.

689 **Хусны үйс**

Birch bark [silver bark]

Цагаан болон цайвар шар өнгөтэй, хагас тунгалаг, гөлгөр нимгэн үе давхаргатай, бие биенээсээ хялбар салдаг хусны холтосны гаднах эд.

690 **Хусны шүүс**

Birch syrup [juice]

Хаврын шүүс хөдлөлтийн үед их хэмжээгээр үүсдэг, хусны модлогийн гуурст агуулагддаг тунгалаг, чихэрлэгдүү шингэн.

691 **Хуш**

Pine Siberian stone [cedar]

[*Pinus sibirica*]

Ой үүсгэгч, 300-550 жил насалдаг, 40 м хүртэл өндөр ургадаг, ишний бүдүүн 1.5 м хүрдэг, мөнх ногоон шилмүүст мод.

692 **Хушны самар**

Pine nut

Сибирь хуш модны үр, түүний урт 10-14 мм, өргөн 6-10 мм, үр жимс хуурай, хатуу бүрхүүлтэй.

693 **Хүйсийн мэдрэмж**

Gender responsive

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэмд хүлээх өөр өөр эрх, үүрэг хариуцлага, тэдний хоорондын харилцааг хүлээн зөвшөөрөхийн тулд нийгэм-соёлын хэм хэмжээ, ялгаварлан гадуурхах байдлыг тооцож, ойлгох мэдрэмж.

694 **Хүлэмж**

Greenhouse [hothouse]

